



МАНДАЛ
ДААТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН **2023**

01

ЧЭЙРМЕНЫ АНАЛИЗ

06

02

БИЗНЕСИЙН ТАЙЛАН

Санхүүгийн үр дүн
9

Андеррайтингийн
үйл ажиллагаа
18

Хөрөнгө оруулалтын
үйл ажиллагаа
27

MNDL хувьцааны тойм
28

Эрсдэлийн удирдлага
31

03

МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

Корпорацийн сайн
засаглал
32

Төлөөлөн удирдах
зөвлөл
44

Менежментийн баг
47

04

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

51



Нийгмийн хариуцлага

Мандал Даатгал ХК нь 2022 онд нийгмийн хариуцлагын хүрээнд “50 ХҮНИЙ АМЬ АВРАХ ТӨСӨЛ”-ийг амжилттай хэрэгжүүлж, тус төслийн хүрээнд дараах 2 ажлыг гүйцэтгэлээ. Эхний хийгдсэн ажил нь Улсын Гуравдугаар Төв эмнэлэгтэй хамтран, тус эмнэлэгт 50 тун алтеплазгийн хөрөнгө оруулалт хийсэн. Алтеплаза нь хурц шигдээс, харвалтын үед анхны шинэ тэмдэг илэрснээс хойш алтан цаг буюу 2-4 цагийн дотор хийгдэх өндөр түвшний эмчилгээ юм. Шигдээс болсноос хойш хугацаа алдалгүй эмнэлгийн тусламж авч, протокол, удирдамжийн дагуу уг эмчилгээг хийхэд амь нас 100% аврагдаж, харвалтаас үүдэх хөдөлмөрийн чадвар алдалт, саа саажилт багасгадаг өндөр үр нөлөөтэй тарилга юм..

Хэдий хүний амь насыг богино хугацаанд аврах шидтэй тун ч гэлээ, нэг алтеплаза тунгийн үнэ өртөг нь өндөр учраас улсын хэмжээнд хүртээмж нөөц хангалтгүй байдаг. Иймд, Мандал Даатгал ХК-аас хүртээмжийг нь нэмэх, нэн яаралтай тулгамдсан үед хүний амь аврах боломжтой энэхүү эмээс 50 тунг захиалан Улсын Гуравдугаар эмнэлэгт хүлээлгэн өгсөн. Одоогийн байдлаар 16 хүнд бүлэн хайлуулах эмчилгээ хийн амь насыг нь авраад байна.

Уг төслийн хүрээнд хийгдсэн дараагийн ажил бол Нийслэлийн Онцгой байдлын ерөнхий газартай хамтран үер усны ослыг бууруулах зорилгоор Туул голын эрэг дагуух хамгийн их хүн цуглардаг хоёр байршлыг сонгон үер усны аюулыг мэдээлэх 2 цамхгийг байгуулсан. Тус хоёр цамхагт 200 метрийн радиуст татаж хардаг хяналтын камерыг байршуулж, тухайн цамхагаас гол дагуух иргэдэд анхааруулж, сэрэмжлүүлэх мэдээллийг дуут дохио ашиглан хүргэж ажиллах нөхцөлийг бүрдүүлжээ. Улаанбаатар хотын хувьд Туул голыг дагасан үер усны эрсдэлтэй бүсэд оршдог тул нийслэлийн ОБЕГ-аас “завьт эргүүл” ажиллуулах, “Анхаарахад л болно” нөлөөллийн аянг тус 2 цамхаг ажиллуулах ажилтай хамтатган хийснээр 2022 онд үер усны ослоос үүдэн амь эрсдэх тохиолдол өмнөх оны мөн үеэс 3.5 дахин буурч, хоёр цамхаг байршсан цэгт ослын тохиолдол бүртгэгддэггүй зэрэг үр дүн гарсан байна. Энэхүү цамхаг нь Олон улсын жишигт нийцсэн иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэж буйгаараа онцлог.

Үүний зэрэгцээ Мандал Даатгал ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна:



+edocto

Таны эрүүл мэндийн итгэлтэй зөвлөх






- **Мандал Эрсдэлийн Сургууль** – 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн уг төсөл нь 4-12 насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгоход чиглэсэн бөгөөд өдгөө 25,000 гаруй хүүхэд багачуудыг онлайн хичээлдээ хамруулаад байна. Монгол Улсад жил бүр 40,000 хүүхэд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирдог харамсалтай тоон мэдээлэл байдаг. Уг эрсдэлийг бид бууруулахын тулд өөрсдийн хувь нэмрийг оруулж, 4-12 насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 2 бүлэг 18 видео хичээлийг тэдний хөгжлийн онцлогт суурилан бэлтгээд байна.
- **ASUUNA** – Өсвөр нас бол эрсдэлтэй зан үйлд татагдах хамгийн өндөр эрсдэлтэй үе байдаг тул энэ хугацаанд хүүхдийг үнэн зөв, баталгаатай, мэргэжлийн мэдээллээр хангах нь чухал юм. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид 2022 оноос эхэлж ASU-UNA платформыг хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэхүү платформ нь 13-18 насны хүүхдүүдэд эрүүл мэнд, үерхэл нөхөрлөл, сэтгэл зүй, өсвөр насны хөгжлийн онцлогтой холбоотой үүсдэг олон асуултуудад мэргэжилтнүүдийн бэлтгэсэн хариултыг хүргэдэг.
- **eDoctor** – Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ юм. Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн билээ. Бид өдгөө 1 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн сантай болоод буй.
- **Мандал Даатгал ХК** нь жил бүр нийгэм эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, менежментийн арга туршлагуудаа хуваалцах зорилгоор Монголын ТОП бизнес эрхлэгчдэд зориулан “Next Leaders”, “Mandal Risk Forum”, “Management Forum” гэх гурван томоохон арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, бизнесийн хүрээлэл болон борлуулалтаа тэлэх боломжийг олгодог гэдгээрээ онцлог. Монгол Улсыг иргэдийнхээ өмнө сайн дураар өөрийнхөө бизнесийн үйл ажиллагаанаас давсан хариуцлага хүлээж чаддаг, хүнлэг том амбицтай компаниуд нэгдэн хөгжүүлж чадна гэдэгт бид итгэлтэй байдаг.

+ edoctor

Таны эрүүл мэндийн итгэлтэй зөвлөх





ЧЭЙРМЕНЫ АНАЛИЗ

A professional portrait of a middle-aged man with dark hair, wearing a dark blue checkered suit jacket, a white shirt, and a patterned tie. He is leaning forward with his hands resting on a dark surface. The background is a dark, textured wall.

ӨЛЗИЙБАЯРЫН
ГАНЗОРИГ

Чэйрмен
Үүсгэн байгуулагч

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ХАРИЛЦАГЧИД, ДААТГУУЛАГЧИД АА

Мандал даатгалын хувьцаа эзэмшигч нь зөвхөн ашигтай, том компанийн эзэн байгаад зогсохгүй, улс орон, ард иргэдийн амьдралд асар их хувь нэмрээ оруулж, бодитой өөрчлөлтийг тасралтгүй авчирдаг компанийн эзэн байх ёстой.

Мандал Даатгал нь санхүүгийн бүхий л үзүүлэлтүүдээрээ даатгалын салбараа тэргүүлж байгааг нийт хувьцаа эзэмшигчиддээ дуулгахад таатай байна.

Монголын хамгийн том даатгалын компани болох Мандал маань 2022 онд 69.7 тэрбум төгрөгний орлоготой ажиллаж салбартаа рекорд тогтоолоо. Мандалын мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө оруулалтын хэмжээ 39.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгө 73.6 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Нөхөн төлбөрийн зардлын өсөлттэй холбоотойгоор цэвэр ашиг төлөвлөсөн дүнгээс бага буюу 4.1 тэрбум төгрөг болсон. Гэхдээ даатгалын бизнесийн үндсэн зорилго нь харилцагч нарт эрсдэл учирсан даруйд хохирлыг нь барагдуулах явдал гэдгийг та бүгддээ дахин сануулах нь зөв. Энэ зорилгынхоо хүрээнд бид харилцагч нартаа нийт 11 тэрбум төгрөгний нөхөн төлбөрийг нийтдээ 20,000 шахам тохиолдлоор олгож салбарынхаа тэргүүлэгч гэдгээ бататгалаа.

2022 онд Мандал Даатгал өмнөх жилүүдэд эхлүүлсэн менежментийн өөрчлөлт, шинэчлэлтийн ажлуудаа үргэлжлүүлсэн юм. Энэ хүрээнд бид цоо шинэ ERP болон CRM систем нэвтрүүлж дууслаа. Хэдэн жилийн турш үргэлжилсэн систем нэвтрүүлэлтийн ажил ийнхүү дууссанаар бид санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь гаргах, дата анализ хийх, мэдээллийн урсгалыг бүрэн хянах зэрэг олон давуу талуудыг бий болгож чадлаа. Мөн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтцийг оновчтой болгох, процессийг сайжруулах, маркетингийг оновчлох төслүүд үргэлжилж байна. Мандал Даатгал нь хөрөнгийн захын томоохон тоглогч болохынхоо хувьд хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын эрсдэлийг хянахад анхаарал

хандуулж ажилладаг. 2022 онд манай хөрөнгө оруулалтын багцын жилийн өгөөж 14% байсан нь даатгалын салбарын дундаж өгөөжөөс (жилийн 9%) хавьгүй өндөр үзүүлэлт юм.

Эцэст нь дурьдахад бид 2022 оны 2-р сараас эхлүүлсэн 50 хүний амь нас аврах төслийнхээ хүрээнд оны эцэс гэхэд 16 хүний алтан амийг аварсан амжилт гаргасан байна. Энэ нь Мандал Даатгал зөвхөн даатгал төдийгүй нийт бизнесийн салбарынхны үлгэр дуурайл болж, хэрэв хүсэл тэмүүлэл байвал хүршгүй зорилт гэж үгүй гэдгийг дахин нотолсон үйл явдал болжээ.



Ө.Ганзориг
Чэйрмен, үүсгэн байгуулагч



БИЗНЕСИЙН ТАЙЛАН


САНХҮҮГИЙН ҮР ДҮН

АШИГТ АЖИЛЛАГАА: МАНДАЛ ДААТГАЛ

“Мандал Даатгал” ХК нь 2022 онд цэвэр ашгийн хэмжээгээр салбартаа тэргүүлэх байр суурийг эзэлж байна. Үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь хөрөнгө оруулалтын орлого өндөр байсан явдал юм. Тодруулбал, мөнгөн хөрөнгөө зүй зохистойгоор нөхцөл сайтай, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулж, хүүгийн болон хөрөнгө оруулалтын өгөөж өндөр байсан болно.

Цэвэр ашиг, тэрбум төгрөг


4.1 тэрбум



Салбарын дундаж түвшинтэй харьцуулахад “Мандал даатгал” ХК нь өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшнээр өндөр байгаа нь капиталын удирдлага, хөрөнгийн ашиглалт сайн байгааг илтгэж байна.


“Мандал даатгал” ХК

14%



Ердийн даатгалын компаниуд

9%




НИЙТ ХӨРӨНГӨ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд нийт хөрөнгийн хэмжээ 58.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 3.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Тус өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь даатгалын үйл ажиллагаа болон цэвэр ашгийн өсөлтүүд юм. 2022 онд бид даатгалын салбартаа нийт хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээгээр тус тус тэргүүлж байна. Мөнгөн хөрөнгийн хэмжээ 2022 онд 38.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байв.

Нийт хөрөнгө, тэрбум төгрөг

73.6 тэрбум




НИЙТ ХӨРӨНГӨ /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны жилийн эцсийн байдлаар 398.2 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 39.4 тэрбум төгрөгөөр буюу 11%-аар өссөн. Үүнд хөрөнгө оруулалтын дүн өмнөх оны мөн үеэс 30.2 тэрбум төгрөгөөр буюу 17%-аар, даатгалын авлага 10.9 тэрбум төгрөгөөр буюу 30%-аар өссөн нь нөлөөлөв. Нийт хөрөнгө нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 13%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Нийт хөрөнгө, тэрбум төгрөг

398.2 тэрбум




МӨНГӨН ХӨРӨНГӨ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд мөнгөн хөрөнгийн хэмжээ 39.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 1.6 тэрбум төгрөгөөр буюу 4%-аар нэмэгдсэн. Харин мөнгөн хөрөнгийн гүйцэтгэл нь 91% байсан ба сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 15%-ийн өсөлттэйгөөр нэмэгдэж буй. Бид 2011 оноос хойш хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ салбартаа тэргүүлж, Моноглын хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүргээ гүйцэтгэсээр байна. Уг амжилтад 2018 онд компанийн нийт хувьцааны 25%-ийг олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаалж хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүлжээ. Мөнгөн хөрөнгө маань сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 15%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Мөнгөн хөрөнгө, тэрбум төгрөг

39.9 тэрбум




МӨНГӨН ХӨРӨНГӨ /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын мөнгөн хөрөнгө 2022 оны жилийн эцсийн байдлаар 231.7 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 24.2 тэрбум төгрөгөөр буюу 12%-аар өссөн байна. Ангиллаар нь харвал: өмнөх оны мөн үеэс мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн 6 тэрбум төгрөгөөр буюу 24%-аар буурч; хөрөнгө оруулалтын дүн 30.2 тэрбум төгрөгөөр буюу 17%-аар өссөн. Мөнгөн хөрөнгө нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 11%-ийн өсөлттэйгөөр нэмэгджээ.

Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтыг авч үзвэл үнэт цаас хэлбэрээр оруулж буй хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь хамгийн өндөр байгаа бол нөгөөтээгүүр хадгаламж, хадгаламжийн сертификатад оруулах хөрөнгө оруулалтын өсөлт буурч байгаа юм. Үүнд Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн холбогдох дүрэм, журмуудад Хорооны 2021 оны 25 болон 64 дүгээр тогтоолуудаар өөрчлөлт оруулж, даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, даатгалын нөөц сан, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахтай холбоотой зохицуулалтыг сайжруулж, даатгагчдын хувьцаа болон бондод оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болсон нь нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Мөнгөн хөрөнгө, тэрбум төгрөг

231.7 тэрбум




НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд “Мандал даатгал” ХК-ийн хувьд нийт хураамжийн орлого 69.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 34.1 тэрбум төгрөгөөр буюу 96%-ийн өсөлттэй тайлагнагдлаа. Компанийн борлуулалтын төлөвлөгөө (50.1 тэрбум төгрөг) 139%-ийн биелэлттэй байв. Түүнчлэн нийт хураамжийн орлогын хэмжээгээр даатгалын зах зээлд эзлэх хувиа 8%-аар ахиулж 23%-д хүргэж ажиллалаа. Ингэснээр нийт хураамжийн орлогоор салбарт эзлэх байраа урагшлуулж 1-р байранд оров. Нийт хураамжийн орлого нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 26%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.


Хураамжийн орлого, тэрбум төгрөг

35.6 тэрбум



Нийт хураамжийн орлого өсөхөд байгууллагын даатгалын борлуулалтын өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд өмнөх оныхоосоо 29.8 тэрбум төгрөг буюу 128%-аар өссөн. Бүтээгдэхүүний хэлбэрээр нь задлан харвал: хөрөнгийн даатгал 26.4 тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 2.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт хураамжийн орлогын 85%-ийг голлох 4 даатгалын хэлбэр эзэлсэн байна.



●	Хөрөнгийн даатгал	48.0%
●	Автотээврийн хэрэгслийн даатгал	15.3%
●	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	10.9%
●	Хариуцлагын даатгал	10.8%
●	Агаарын хөлгийн даатгал	5.4%
●	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	3.1%
●	Бусад	6.5%


НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 298 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 54.8 тэрбум төгрөгөөр буюу 23%-иар өссөн байна. Бүтээгдэхүүний хэлбэрээр нь харвал: өмнөх оны мөн үеэс автотээврийн хэрэгслийн даатгал 23.3 тэрбум төгрөгөөр буюу 47%-аар; гэнэтийн осол, эмчилгээний даатгал 21.1 тэрбум төгрөгөөр буюу 68%-аар; жолоочийн хариуцлагын даатгал 13.2 тэрбум төгрөгөөр буюу 35%-аар тус тус өссөн. Нийт хураамжийн орлого нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 18%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Хураамжийн орлого, тэрбум төгрөг

298.0 тэрбум

22	298.0
21	243.2
20	186.8
19	193.6
18	155.6



●	Автотээврийн хэрэгслийн даатгал	24.4%
●	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	17.4%
●	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	17.0%
●	Хөрөнгийн даатгал	16.7%
●	Хариуцлагын даатгал	7.4%
●	Барилга угсралтын даатгал	4.4%
●	Бусад	12.7%

ДААТГУУЛАГЧДЫН ТОО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Бид 55,270 хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж ажиллалаа. Энэ нь өмнөх оныхоос 35%-аар өссөн үзүүлэлт юм.

Даатгуулагчдын тоо

55.270

22		55,270
21		41,031
20		51,459
19		54,380
18		70,310

НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ өмнөх оноос 0.4 тэрбум төгрөгөөр буурч 6.6 тэрбум төгрөгт хүрсэн. 2022 онд компанийн нөөц сангийн хүрэлцээний түвшин 1.8 буюу хангалттай байгаа юм. Сүүлийн 4 жилийн нийлмэл өсөлт нь 18%-тай байна.

Нөхөн төлбөрийн нөөц сан, тэрбум төгрөг

6.6 тэрбум

22		6.6
21		7.0
20		6.4
19		4.6
18		3.4

НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын хувьд нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ өмнөх оноос 4.4 тэрбум төгрөгөөр буурч 46.4 тэрбум төгрөгт хүрсэн. Сүүлийн 4 жилийн нийлмэл өсөлт нь 1%-тай байна.

Нөхөн төлбөрийн нөөц сан, тэрбум төгрөг

46.4 тэрбум


22		46.4
21		50.8
20		56.7
19		46.1
18		44.8

НӨХӨН ТӨЛБӨР /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Бид харилцагчдаас хүлээн авсан эрсдэлийн багцын томоохон хэсгийг олон улсын давхар даатгалын зах зээл дээр байршуулж ажилладаг билээ. Ингэснээр, компанийн төлбөрийн чадварыг хамгаалж, харилцагчдын нөхөн төлбөр найдвартай, баталгаатай төлөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг. 2022 онд нийт 11.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон ба өмнөх оныхоосоо 2.9 тэрбум төгрөгөөр буюу 36%-аар нэмэгдсэн. Бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харвал: жолоочийн хариуцлагын даатгал 1.1 тэрбум төгрөгөөр буюу 109%-аар; автотээврийн хэрэгслийн даатгал 0.6 тэрбум төгрөгөөр буюу 19%-аар; гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 0.5 тэрбум төгрөгөөр буюу 18%-аар; агаарын хөлгийн даатгал 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ. Сүүлийн 4 жилийн нийлмэл өсөлт нь 27%-тай байна.

Нийт нөхөн төлбөр, тэрбум төгрөг

11.1 тэрбум




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд үйл ажиллагааны зардал 9.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбумаар буюу 18%-иар өссөн байна. Энэ нь төлөвлөгөө буюу 11.7 тэрбум төгрөгөөс 2.1 тэрбум төгрөгөөр бага буюу биелэлт 82%-тай байсан болно.

Үйл ажиллагааны зардал, тэрбум төгрөг

9.7 тэрбум




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал 2022 онд 69.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 6.8 тэрбум төгрөгөөр буюу 11%-аар өссөн байна. Үйл ажиллагааны зардал нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 14%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Үйл ажиллагааны зардал, тэрбум төгрөг

69.7 тэрбум




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Мандал даатгал ХК нь хөрөнгө оруулалтын багцын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Хөрөнгө оруулалтын удирдлага нь компанийн хөрөнгө оруулалтын багцыг өдөр бүр тогтмол хянан, эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг.

2022 онд хөрөнгө оруулалтын орлого 4.89 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 0.13 тэрбум төгрөгөөр буюу 3%-аар буурч, төлөвлөгөө болох 5.15 тэрбум төгрөгөөс 0.25 тэрбум төгрөгөөр бага буюу биелэлт 95%-тай байсан. Бид хөрөнгө оруулалтын орлогоор салбарт эзлэх байраа урагшлуулж 1-р байранд орлоо. Хөрөнгө оруулалтын орлого маань сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 21%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм

Хөрөнгө оруулалтын орлого, тэрбум төгрөг

4.9 тэрбум




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын орлого 2022 онд 17.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 12.3 тэрбум төгрөгөөр буюу 41%-аар буурсан байна. Хөрөнгө оруулалтын орлого нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 1%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Хөрөнгө оруулалтын орлого, тэрбум төгрөг

17.3 тэрбум




ЦЭВЭР АШИГ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд компанийн цэвэр ашиг 4.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оныхоос 1.5 тэрбум төгрөгөөр буюу 27%-аар буурсан. Компанийн цэвэр ашгийн төлөвлөгөө (4.3 тэрбум төгрөг) 95%-ийн биелэлттэй байв. Цэвэр нөхөн төлбөр өмнөх онтой харьцуулахад 2.8 тэрбум төгрөг буюу 41%-аар өссөн нь цэвэр ашигт сөрөг нөлөө үзүүлсэн. Бид цэвэр ашгийн үзүүлэлтээр салбарт эзлэх байраа урагшлуулж 1-р байранд орлоо. ТУЗ-ийн зүгээс компанийн цэвэр ашгийн үр дүн, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг дээр үндэслэн ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн болно.

Компанийн цэвэр ашгийн үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд тогтмол эерэг үзүүлэлттэй гарсан ба сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 1%-ийн өсөлттэй байлаа.

Цэвэр ашиг, тэрбум төгрөг

4.1 тэрбум




ЦЭВЭР АШИГ /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг 2022 онд 15.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.3 тэрбум төгрөгөөр буюу 29%-аар буурсан байна. Цэвэр ашиг нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 4%-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

Цэвэр ашиг, тэрбум төгрөг

15.2 тэрбум



НИЙЛМЭЛ ХАРЬЦАА /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2022 онд нийлмэл харьцаа 104%-д хүрсэн. Тус харьцаа буурах тусам ашигт ажиллагаа сайжирч байгааг харуулдаг. 2022 оны ердийн даатгалын компаниудын дундаж нийлмэл харьцаа 101% байсан ба "Мандал даатгал" ХК-ийнх тус түвшнээс 3%-аар их байлаа. 2022 онд цэвэр нөхөн төлбөр өмнөх оныхоосоо 41%-аар, хохирлын харьцаа 11%-аар өссөний улмаас нийлмэл харьцаа өмнөх оныхоос 16%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа юм. Нийлмэл харьцааг 98%-д барина гэж төлөвлөж байсан хэдий ч нөхөн төлбөрийн зардлын хэт их өсөлт үүнд сөрөг нөлөө үзүүлээ.

Нийлмэл харьцаа

104%



НИЙЛМЭЛ ХАРЬЦАА /ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИУД/

Ердийн даатгалын компаниудын нийлмэл харьцаа 2022 онд 101%-д хүрсэн. 2022 онд цэвэр нөхөн төлбөр өмнөх оныхоосоо 28%-аар, хохирлын харьцаа 1%-аар өссөн бол зардлын харьцаа 3%-аар буурсны улмаас нийлмэл харьцаа өмнөх оныхоос 2%-аар буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Нийлмэл харьцаа

101%

22		101%
21		103%
20		80%
19		97%
18		101%

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Төлбөрийн чадварын харьцаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх болон ирээдүйд учрах томоохон эрсдэлийг даахад хүрэлцэхүйц хөрөнгөтэй эсэхийг харуулдаг үзүүлэлт билээ. 2022 онд төлбөрийн чадварын харьцаа 133%-тай тайлагнагдаж Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигдах шаардлага болон 110%-ыг хангасан болно.

Төлбөрийн чадварын харьцаа

133%

22		133%
21		144%
20		166%
19		158%
18		151%

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Андеррайтингийн үйл ажиллагааны зорилго, зорилт

ЗӨВ ЭРСДЭЛИЙН БАГЦ БҮРДҮҮЛЭХ

Мандал Даатгал ХК нь өөрийн Андеррайтингийн бодлогын хүрээнд даатгалын бүтээгдэхүүн бүрийг дараах 3 үндсэн шалгуураар үнэлж, бүтээгдэхүүний зөв багцыг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үүнд:

- Зах зээлийн багтаамж
- Хохирлын харьцаа
- Андеррайтингийн туршлага

Зөв эрсдэлийн багц бүрдүүлэх нь нэг талаас компанийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нөгөө талаас даатгуулагчдад нөхөн төлбөрийг түргэн шуурхай, найдвартай олгоход чиглэж буй юм.

ДААТГАЛЫН БОЛОН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ИНЖЕНЕРИЙН ШИЙДЭЛ САНАЛ БОЛГОХ

Манай мэргэжлийн инженерийн баг даатгуулагчийн эрсдэлийг үнэлж үзсэний үндсэн дээр тухайлсан даатгалын шийдэл болон даатгуулагчийн эрсдэлийг бууруулах аргачлал, төлөвлөгөөг боловсруулж санал болгож байна. Улмаар даатгуулагчийн болон компанийн аль алиных нь эрсдэл буурч харилцан өгөөжтэй хамтран ажиллах үндэс бий болох юм.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НУТАГШУУЛАХ, АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ

Бид 2018 оноос голлох даатгалын бүтээгдэхүүнүүдийн гэрээг Lloyds', Munich Re зэрэг олон улсад даатгалын гэрээний стандарт тогтоогч мэргэжлийн оролцогчдын туршлага болон Монголын даатгалын зах зээлийн онцлог, шинж чанарт нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 11 стандарт бүтээгдэхүүнтэй болсон байна. Үргэлжлүүлэн олон улсын туршлагатай андеррайтеруудтай хамтарч андеррайтингийн үйл ажиллагааг автоматжуулах чиглэлд ажиллаж байна.

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТООГООР

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн үзүүлэлтүүд сая төгрөг	2021	2022
Нийт гэрээний тоо	121,719	130,414
Нийт хураамжийн орлого	35,615	69,687
Нийт нөхөн төлбөрийн дүн	8,150	11,062
Хохирлын харьцаа	36%	47%
Хийсэн эрсдэлийн үнэлгээний тоо	31	40

Онцлох өөрчлөлт, хөгжүүлэлт

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оноос харилцагч нартаа даатгалын бүтээгдэхүүнээс гадна эрсдэлийн удирдлагын цогц үйлчилгээг санал болгож ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг нийцүүлсэн стандартууд:

1. MNS ISO 31010:2011 "Эрсдэлийн Менежментийн Стандарт"
2. Монгол улсын хөдөлмөрийн сайдын тушаалаар батлагдсан "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж"
3. Олон улсад эрсдэлийн үнэлгээ, удирдлагын үйлчилгээ үзүүлэгч FM Global, Cunningham

ДААТГУУЛАГЧ НАРТ САНАЛ БОЛГОЖ БҮЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж өгөх

- Хөрөнгийн эрсдэлийн үнэлгээ
- Тоног төхөөрөмжийн эрсдэлийн үнэлгээ
- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ
- Гал болон цахилгааны эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт

- Галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал

Эрсдэл бууруулах ажлыг удирдан зохион байгуулах

- Эрсдэл бууруулах ажлын төсвийн тооцоолол, судалгаа
- Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн хяналт
- Гүйцэтгэлийн дараах явцийн хяналт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГУУД

2021 оноос эхлэн нийтдээ 40 орчим объектод эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэл бууруулах зөвлөмж хүргүүлж хамтарч ажилласан байна.



MCS estates



БОСА ХОЛДИНГ



ТҮМЭН ШУВУУТ
Аз жаргалыг үйлдвэрлэлт

ГОПОМТ БАНК




UNITEL

JCB
UL EQUIPMENT CO.

WORLD FINANCIA
history museum

Багцын эрсдэлийн удирдлага



БАГЦЫН ТӨВЛӨРӨЛ БА АНДЕРРАЙТИНГИЙН ТУРШЛАГА

Багцын бүрдэл



Бид өөрсдийн андеррайтингийн туршлага, давуу талд үндэслэн бүтээгдэхүүний багцаа бүрдүүлдэг ба голлох 3 бүтээгдэхүүний хувьд ялгарах онцлогуудыг дурдвал:

1. Авто тээврийн хэрэгслийн даатгал

- Харилцагчийн сегмент бүрд зориулсан тусгай бүтээгдэхүүнүүд
- Эрсдэл багатай харилцагчийг урамшуулах систем
- Баталгаат засварын бирж
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- Технологид суурилсан нөхөн төлбөр шийдвэрлэлт ("Мандал" аппликейшн-ээр зайнаас ослын үзлэг баримтжуулалт, нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт хийх)
- Тээврийн хэрэгслийн осол, хохирлын шалтгаан тодорхойлох гэрээт экспертүүд

2. Хөрөнгийн даатгал

- Олон улсын стандартад нийцүүлэн гаргасан бүтээгдэхүүн, гэрээний нөхцөл
- Даатгуулагчийн эрсдэлийн түвшинг үнэлэх, эрсдэл бууруулах ажлын зөвлөмж өгөх мэргэжлийн инженерийн баг
- Гал, цахилгаан, сангийн чиглэлийн эрсдэлийн удирдлагын сургалт
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- Даатгуулагчид учирч болох хамгийн их эрсдэл (PML)-ийн тооцоолол

3. Жаргалан эрүүл мэндийн даатгал

- Эрүүл мэндийн даатгалаар мэргэшсэн андеррайтеруудын баг
- Нөхөн төлбөр хариуцсан мэргэжлийн эмч нарын баг
- Монголд хамгийн том эмнэлэгийн сүлжээ
- Эмнэлэг дээрх харилцаа, үйлчилгээ хариуцсан тусгай менежер
- Эрүүл мэндийн даатгалын тусгай лавлах

ХУРААМЖ ТООЦООЛУУР

Бид 2019 оноос доорх даатгалын бүтээгдэхүүнүүдийн хүрээнд эрсдэлийн дата мэдээлэлд үндэслэн хураамжийн дүнг тооцоолдог моделийг боловсруулан андеррайтингийн үйл ажиллагаандаа ашиглаж байна:

- Үл хөдлөх хөрөнгийн даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Машин механизмын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Тоног төхөөрөмжийн даатгал
- Ажилчдын осол, нөхөн олговрын даатгал
- Галын даатгал

Андеррайтингийн тоон үзүүлэлтүүд

ХУРААМЖИЙН ОРЛОГО

2022 оны 69.7 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний төрлөөр ангилж харвал дараах бүтэцтэй байна.

Хураамжийн орлого даатгалын хэлбэрээр	2021		2022	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	7,621	21%	10,652	15%
Хариуцлагын даатгал	7,586	21%	8,181	12%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	7,544	21%	7,342	11%
Хөрөнгийн даатгал	6,611	19%	33,478	48%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,489	4%	2,139	3%
Санхүүгийн даатгал	1,248	4%	775	1%
Бусад	3,517	10%	7,118	10%
Нийт	35,615	100%	69,687	100%

НӨХӨН ТӨЛБӨР

Мандал даатгал ХК нь 2022 онд нийт 20,196 даатгалын тохиолдолд нийт 11 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд даатгалын тохиолдлын тоог даатгалын хэлбэрээр өмнөх онтой харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нийт нөхөн төлбөр даатгалын хэлбэрээр	2021		2022	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,421	42%	4,059	37%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3,038	37%	3,578	32%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,014	6%	2,122	19%
Хөрөнгийн даатгал	599	16%	697	6%
Хариуцлагын даатгал	79	3%	101	1%
Бусад	0	0%	505	1%
Нийт	8,150	100%	11,062	100%

2022 онд Мандал даатгал нь нийт 11.1 тэрбум төгрөгийн 11% буюу 1.3 тэрбум төгрөгийг давхар даатгагчаар төлүүлсэн бол үлдсэн 9.8 тэрбум төгрөг буюу 89%-ийг дангаараа хариуцан нөхөн төлбөр олгосон байна.

БАГЦЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Компанийн 2022 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 11%-иар өсч 47% болсон үр дүнтэй байна. Нөхөн төлбөрийн бүтээгдэхүүнээр задлан харвал: гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн албан журмын даатгалын хувьд нийт олгосон нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх онтой харьцуулбал дунджаар 40%-иар өссөн.

Хохирлын харьцаа даатгалын хэлбэрээр	2021	2022
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	36%	45%
Барилга угсралтын даатгал	0%	0%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	56%	58%
Хөрөнгийн даатгал	7%	12%
Хариуцлагын даатгал	8%	10%
Бусад	61%	118%
Нийт	36%	47%


Нөөц сан тооцоолол

Мандал даатгал ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1-р сарын 9-ний өдрийн №2 тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн Хавсралт №3, “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу нөөц сангийн тооцооллыг хийдэг.

- 2022 оны эцэст 6.6 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулсан.
- Нөөц сангийн тооцооллын хүрээнд 2020 оноос эхлэн нөөц сангийн зохист түвшинг тодорхойлж эхэлсэн ба 2022 оны нөөц сангийн хэмжээ хүрэлцээтэй түвшинд байна.
- Нөөц сангийн хэмжээг 2017 оноос хойш харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нөөц сан, тэрбум төгрөг

6,595 тэрбум



ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Даатгалын компани даатгуулагчийн өмнө хүлээсэн
үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг
“Давхар даатгал” гэнэ. Энгийнээр давхар даатгал нь
даатгалын компанийн даатгал юм.*

Мандал Даатгал ХК нь өөрийн санхүүгийн чадавхаас давсан эсхүл хариуцах сонирхлоос гадуурх эрсдэлүүдийг олон улсын зэрэглэл тогтоох агентлаг A.M.Best Company-ийн “А-”; S&P, Fitch Group-ийн “BBB”; Moody's Corporation-ийн “Baa”-аас дээш үнэлгээтэй давхар даатгагчдад багцлан эсхүл эрсдэл тус бүрээр үнэлэн давхар даатгуулан ажиллаж байна.

ТРИТИ ДАВХАР ДААТГАЛ

Даатгалын компани өөрийн сонгосон эрсдэлүүдийн хувьд оновчтой хэмжээний давхар даатгалын хамгаалалттай байх зорилгоор тухайн хамгаалалтын бүхий л нөхцөлийг давхар даатгагчидтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр гэрээт давхар даатгалын хамгаалалтыг худалдан авдаг.

Бид дэлхийд хураамжийн орлогоороо эхний тавд жагсдаг Франц Улсын давхар даатгагч Скор РЭ, Герман Улсын давхар даатгагч Ханновэр РЭ, Монгол Улсын давхар даатгагч Үндэсний Давхар Даатгал Хувьцаат Компанитай гэрээлэн, хөрөнгө, хөрөнгийг дагасан бизнес тасалдал, барилга, угсралтын бүх эрсдэл, байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, мэргэжлийн хариуцлага, ажил олгогчийн хариуцлага, хүнд даац, тусгай зориулалтын машин механизм, ачаа тээврийн гээд нийт 8 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгуулан ажиллаж байна. Компанийн трити давхар даатгалын гэрээний хамгаалалтыг дор хүснэгтэд үзүүлэв.

Бүтээгдэхүүний төрөл	Дэд хязгаар /USD/	Нийт хамгаалалт
Хүнд даац, тусгай зориулалтын машин механизмын даатгал	2,000,000	
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал		
Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал		5,000,000
Мэргэжлийн хариуцлагын даатгал	3,000,000	
Ажил олгогчийн хариуцлагын даатгал		
Ачаа тээврийн даатгал		
Хөрөнгийн даатгал	5,000,000	
Барилга угсралтын бүх эрсдэлийн даатгал		

Даатгалын тохиолдол гарсан үед гэрээгээр даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн, нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэх нь маш чухал. Иймд, бид олон улсын үнэлгээний агентлагуудаас А болон түүнээс дээш үнэлгээ авсан давхар даатгагчидтай трити давхар даатгалын гэрээний хүрээнд хамтарч ажиллаж байна.

Давхар даатгагчид

Олон улсын
үнэлгээ



A+ (AM Best)

hannover re

A+ (ACRA)

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Бид салбартаа анхдагчийн нэг болох 30 жилийн түүхт Aspire Lifestyle (HK) Limited-ын International SOS үйлчилгээг санал болгон ажиллаж байна. Уг хамгаалалт нь даатгуулагчид дэлхийн өнцөг булан бүрээс яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай үед түргэний тээвэрлэлтийн үйлчилгээг 1 сая ам.доллар хүртэлх хязгаарт багтаан үзүүлдгээрээ онцлогтой.



AA- (Standard & Poor's)

Бид, International SOS үйлчилгээг 30 жилийн түүхт салбартаа анхлагчдын нэг бөгөөд тэргүүлэгч Aspire Lifestyles (HK) Limited-ээс харилцагчдадаа санал болгосоор байна. Энэхүү хамгаалалт нь дэлхийн өнцөг булан бүрээс яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай нэгэнд түргэний тээвэрлэлтийн үйлчилгээг 1 сая ам доллар хүртэлх хязгаарт багтаан үзүүлдгээрээ онцлогтой.



ДАЛД УУРХАЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

Мандал Даатгал ХК нь харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн далд уурхайн эрсдэлийн хариуцлагын даатгалуудыг Ллойдс-д бүртгэлтэй олон улсад А болон түүнээс дээш зэрэглэлтэй давхар даатгагчидтай хамтран санал болгож байна. Бид 1 сая ам.доллароос 50 сая ам.доллар хүртэлх байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, бохирдлын хариуцлага, ажил олгогчийн хариуцлага зэргийг давхар даатгалд 100% байршуулах боломжтой. Далд уурхайн мэргэжлийн хариуцлагын давхар даатгагчдын хувьд андеррайтингийн мэдээлэлд үндэслэн ажлын 10 хоногт багтаан үнийн саналыг хүргүүлэх боломжтой.

LLOYD'S A+ (Standard & Poor's)

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 онд Мандал Даатгал ХК нь 46.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын нийт хураамжийн орлогыг бүрдүүлж ажилласан бөгөөд уг орлогыг бүтээгдэхүүний хэлбэрээр нь задлан харвал дараах байдалтай байна:

Даатгалын хэлбэр	ДД-н хураамжийн дүн	Эзлэх хувь
Хариуцлагын даатгал	7,124.83	15%
Хөрөнгийн даатгал	29,166.16	63%
Агаарын хөлгийн даатгал	3,794.60	8%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,320.56	3%
Бусад	4,866.64	11%
Нийт (сая төгрөгөөр)	46,272.79	100%
Нийт	100%	100%

2022 онд Мандал даатгал нь нийт 11.1 тэрбум төгрөгийн 11 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг давхар даатгагчаар шийдвэрлүүлсэн. Нийт давхар даатгалын нөхөн төлбөрийг бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харвал дараах байдалтай байна:

Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөрийн дүн	Эзлэх хувь
Хүнд даац, тусгай зориулалтын механизм	0.57	0%
Агаарын хөлгийн даатгал	409.60	32%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	701.96	56%
Хөрөнгийн даатгал	149.68	12%
Нийт (сая төгрөгөөр)	1,261.80	100%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багц бүрдүүлэлтийн төлөвлөгөөг макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал болон хөрөнгө оруулалтын боломжууд дээр үндэслэн эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийдэг.

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2021	2022	Өсөлт
Мөнгөн хөрөнгө	38.3	39.9	4%
Хөрөнгө оруулалтын орлого	5.0	4.9	-3%

* Хөрөнгө оруулалтын орлогод хувьцааны дахин үнэлгээний нэмэгдлийг оруулж тооцсон болно.



Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо, Монголбанк

Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2022 оны 12 сарын 31-ны өдрөөр харвал дараах байдалтай байна:

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2022	Өсөлт
Бэлэн мөнгө	1%	4%
Хадгаламж	3%	3%
Бонд	68%	68%
Итгэлцэл	10%	10%
Хөрөн гөөр баталгаажсан үнэт цаас	1.0	2%
Хувьцаа	2.2	6%
Бусад	4.0	10%
Нийт	39.9	100%

MNDL ХУВЬЦАА

Хувьцааны мэдээлэл

Мандал Даатгал ХК нь 2018 оны 9-р сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25%-ийг санал болгон нийт 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан хувьцаат компани болсон түүхтэй билээ.

Зах зээлийн үнэлгээ

52.5 тэрбум төгрөг

Нийт хувьцааны тоо

624,301,600 ширхэг

Хаалтын ханш 12/31/2021

84.17 төгрөг

Эх сурвалж: МХБ

Нэгж хувьцааны ханш 2022 онд 98.92 төгрөгөөр эхэлсэн бол оны эцэст буюу 2022 оны 12 сарын 31-ний өдөр 84.17 төгрөгт хүрч компанийн зах зээлийн үнэлгээ 52.5 тэрбум төгрөгт болж хаагдсан байна.

EPS

6,5

P/E харьцаа

12,9

P/B харьцаа

1,8

ROA /нийт
хөрөнгийн өгөөж/

6%

ROE /өөрийн
хөрөнгийн өгөөж/

14%

Эх сурвалж: Компанийн тайлан, МХБ

Хувьцааны арилжаа

Мандал даатгал ХК-ийн хувьцаа нь MNDL симболтойгоор Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд арилжаалагдаж байна. Энэ ангилалд сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх зэрэг чанарын үзүүлэлт хангасан 23 компани багтдаг.

Мандал Даатгал ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн компаниуд дундаас 2022 оны арилжааны тоогоор 5 дугаарт, арилжааны дүнгээр 14 дүгээрт жагслаа.

Нийт арилжааны дүн

2.5 тэрбум төгрөг

Өдрийн дундаж арилжаа

10.2 сая төгрөг

Өдрийн дундаж арилжааны ширхэг

97,162 ширхэг

52 долоо хоног өндөр ханш

150.17 төгрөг

52 долоо хоног бага ханш


73.53 төгрөг

Эх сурвалж: МХБ


ТОП-20 индекс ба MNDL хувьцааны ханшийн хамаарал

Зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтээрээ манлайлсан жишиг ТОП-20 компанийн индексийн үзүүлэлтэд 2019 онд багтсанаас хойш 4 жилийн турш тасралтгүй энэхүү индексэд багтаж байна. ТОП-20 индекс нь 2022 онд 43,901 нэгжээс эхэлж оны эцэст 37,566 нэгжээр хаагджээ.

ТОП-20 индекс ба MNDL хувьцааны ханшийн хамаарал



2022 ОНЫ MNDL ХУВЬЦААНЫ ҮНЭ БА АРИЛЖААЛАГДСАН ШИРХЭГ



Ногдол ашиг ба ногдол ашгийн бодлого

Анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгож хөрөнгө татсанаас хойш санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан жил бүр ногдол ашиг олгосон бөгөөд 2019, 2020 болон 2021 оны цэвэр ашгаас тус бүр 43%, 41%, 33%-ийн ногдол ашиг олгох шийдвэр гаргасан.

Ногдол ашиг	Нэгж хувьцаанд ногдох ашиг, төгрөг	Хувьцааны тоо, ширхэг	Нийт ногдол ашиг, төгрөг	Татварын дараах ашиг, төгрөг	Ногдол ашиг олголтын хувь, DPR*
2018	100	6,243,016	624,301,600	3,868,257,250	16%
2019	4	624,301,600	2,497,206,400	5,870,586,590	43%
2020	3	624,301,600	1,872,904,800	4,534,068,159	41%
2021	3	624,301,600	1,872,904,800	5,607,990,921	33%
2022	-	624,301,600	-	4,084,406,848	-

* Dividend payout ratio

Бид цэвэр ашгийн түвшнийг нэмэгдүүлэхийн тулд мөнгөн хөрөнгө, түүнээс олох хөрөнгө оруулалтын орлогоо нэмэгдүүлэх зорилгоор 2022 онд ногдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсэн.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Бид бусдын эрсдэлийг шилжүүлэн авч удирдахын суурь чадамж нь өөрийн эрсдэлийг удирдах явдал гэж үзэн, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг.

Мандал Даатгал нь урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгож, стратегийн зорилтуудад хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Даатгалын компани нь бусдын эрсдэлийг өөртөө хүлээн авах, өөрийн дааж чадах хэмжээнээс илүү эрсдэлийг давхар даатгалд шилжүүлэх үндсэн үйл ажиллагаа явуулдгийн хувьд компани өөрийн эрсдэлээ удирдах нь бидний зайлшгүй үүрэг, хариуцлагын нэг гэж үздэг.

Бид эрсдэлийг илрүүлэх, судлах, оновчтой удирдах арга аргачлалыг боловсруулж, компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн, эрсдэлийг илэрхийлэх индикаторууд, даатгалын онцлог харьцаа үзүүлэлтүүд, үйл ажиллагааны хяналт болон тайлагналын тогтолцоог тогтмол хэрэгжүүлэн

ажиллаж байна. Үндсэн гол үзүүлэлтүүдээс авч үзвэл даатгалын андеррайтингийн үйл ажиллагааг үнэлдэг хохирлын болон зардлын харьцаанууд юм.

Нийлмэл харьцаа нь хохирлын харьцаа болон зардлын харьцааны нийлбэр ба уг үзүүлэлт 100 хувиас бага байх нь даатгалын үйл ажиллагаа өгөөжтэй байсныг илэрхийлдэг. 2022 онд цар тахлын дараах эдийн засаг, Орос Украины дайнаас үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдал нь даатгалын салбарт хүчтэй нөлөөлж компанийн нийлмэл харьцаа 104%-д хүрсэн ба салбарын нийлмэл харьцаа 105%-д хүрсэн нь эдийн засгийн нөхцөл байдал салбарын бүх даатгалын компанид нөлөөлснийг илтгэж байна.

Харьцаа үзүүлэлтүүд	2020	2021	2022
Хохирлын харьцаа	42%	36%	45%
Нийлмэл харьцаа	95%	88%	104%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (Шалгуур $\geq 110\%$)	161%	144%	133%

Төлбөрийн чадварын харьцаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх болон ирээдүйд учрах томоохон эрсдэлийг даахад хүрэлцэхүйц хөрөнгөтэй эсэхийг харуулдаг үзүүлэлт билээ. 2022 онд төлбөрийн чадварын үзүүлэлт 133 хувь байгаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигдах шаардлагыг хангасан үзүүлэлт юм.

Эрсдэлийн засаглал

Компанийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь бизнесийн стратеги зорилтуудад хүрэх явцад учирч болзошгүй саад тотгор, эсхүл илүү боломж буюу ердийн үйл ажиллагааг савлуулахад хүргэдэг хэвийн бус нөлөөллийг хэмжиж, түүнд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх замаар эрсдэл өгөөжийн оновчтой түвшинг хадгалах явдал юм.

Компанийн эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэх, эрсдэлийг удирдах соёлыг бий болгоход менежментийн зүгээс анхаарч, чиглүүлэн

ажилладаг. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд компанийн удирдлага, ажилтнууд дараах үүрэгтэйгээр оролцдог.

Эрсдэлийн оноо	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинг ойлгох	Хариуцах удирдлага
1-3.	Маш бага, Бага	Хүлээн зөвшөөрөх	Нэгжийн удирдлага
4-10.	Дунд	Анхаарал хандуулах	Шугаман удирдлага
11-19.	Их	Ноцтой	Гүйцэтгэх захирал, ГЗО
20-25.	Маш их	Аюултай	ТУЗ

Эрсдэлийн төрөл ангилал

Эрсдэлийг компанийн үндсэн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай уялдуулан дараах төрлүүдэд ангилан тодорхойлсон. Эрсдэлийг бүтэн дүр зургаар харж тодорхойлох, урьдчилан сэргийлэх, удирдах нь компанийн эрсдэлийн бодлогын гол зорилго юм. Тиймээс дээрх эрсдэлүүдээс гадна шинээр бий болж буй болон гэнэтийн эрсдэлүүдийг тодорхойлж, удирдах нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг.

ажиллагааг хариуцан ажиллах бие даасан нэгж байгуулагдаж ажилладаг болсон. Зах зээл дээрх хүүний түвшин бууралтын нөлөө 2022 онд арилаагүй ба хөрөнгө оруулалтын өгөөж буурах эрсдэл хэвээр үргэлжилсэн нь хөрөнгө оруулалтын бодлогыг үүнтэй уялдуулан тасралтгүй шинэчлэн сайжруулж хөрөнгө оруулалтын өгөөж буурах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалт болон багцын хяналтын үзүүлэлтүүдийг шинээр тусгаж ажилласан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- Мандал Даатгал ХК нь 2022 оны 06-р сарын 16-ны өдөр тохиолдож болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, компанийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээний хэрэгжилтийг хянах, эрсдэлээс сэргийлэх соёлыг бий болгох зорилгоор “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ыг батлан, мөрдлөг болгон ажиллаж байна.
- Даатгалын компанийн нэн чухал эрсдэл нь хөрөнгө оруулалтын эрсдэл байдаг. Компани байгуулагдсан цагаас хойш хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг санхүүгийн хэлтэс хариуцан ажиллаж байсан бол 2020 оноос хойш хөрөнгө оруулалтын үйл

- Даатгалын компанийн хувьд харилцагчаас шилжүүлж авсан эрсдэлийг өөрийн дааж чадах эрсдэлийн түвшнээс давсан хэсгийг давхар даатгалд шилжүүлэх нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг. Үүний хүрээнд бид 2022 онд трити давхар даатгалын гэрээгээ сунгах, факультатив давхар даатгалуудыг хугацааны хоцрогдолгүйгээр, тухай бүрд нь давхар даатгалд байршуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

- 2022 онд технологийн дэвшлийг ашиглан дотоод үйл ажиллагааны системийг сайжруулж эрсдэлийн тохиолдлууд, асуудлын бүртгэлийн санг боловсронгуй болгож, эрсдэлийн үнэлгээний матрицын дагуу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан амжилттай хэрэгжүүлж гүйцэтгэлийг хянаж ажилласан.

Эрсдэлийн төрөл, ангилал

Хууль, зохицуулалтын эрсдэл

Хууль, зохицуулалтын эрсдэл

Компани холбогдох хууль, журам зөрчих, бүтээгдэхүүн борлуулах эрхээ алдах, үйл ажиллагаагаа бүр болон түр хугацаагаар хаалгах, компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй хууль, журам батлагдах эрсдэл

Давхар даатгалын эрсдэл

Компани өөрийн санхүүгийн чадавх болон эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшнээс давсан хэсгийг давхар даатгалд байршуулж чадахгүй байх, давхар даатгалын гэрээ ба дотоод гэрээний нөхцөлд зөрүү үүсэх, давхар даатгагч төлбөрийн чадваргүй

Үйл ажиллагааны эрсдэл

Борлуулалтын эрсдэл

Эдийн засгийн нөхцөл байдал, засгийн газрын зохицуулалт, олон тооны өрсөлдөгч зэрэг нь борлуулалтын орлогод нөлөөлж байдаг. Зорилтот зах зээл дээр борлуулах даатгалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэтэй холбоотой тодорхойгүй нөхцөл байдлыг борлуулалтын эрсдэл гэж үзнэ.

Ёс зүйн эрсдэл

Компанийн ёс зүйн дүрмийг мөрдөөгүйгээс үүдэн гарах эрсдэл юм.

Хүний нөөцийн эрсдэл

Компанийн ажилчид гэнэт ажлаас гарах, хүндээр өвдөх, ажил эрхлэх боломжгүй болох, мөн нэгэн зэрэг олон ажлын байр ажилтангүй байснаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаа доголдох, бүтээмжид нөлөөлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой эрсдэлүүдийг бүхэлд нь ойлгоно.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Мэдээллийн системийн аюулгүй байдал, мэдээлэл технологийн програм хангамжуудын тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой, компанийн мэдээлэл алдагдах, хакердуулах гэх мэт эрсдэл.

Ажлын байрны эрсдэл

Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс, гадны нөлөө болон бусад хүчин зүйлсийн улмаас оффисын барилга галд өртөх, нурах, эвдэрч гэмтэх, сантехникийн эвдрэл үүсч ус алдах, хөлдөлт үүсэх, хулгайд өртөх болон оффист цахилгааны гэмтэл үүссэний улмаас цахилгаан тасрах, цахилгаан хэрэслүүд шатах зэрэг компанийн оффист тохиолдох эрсдэлийг бүхэлд нь ойлгоно.

Комплаенсийн эрсдэл

Гэмт хэргийн буюу илт хууль бус замаар олсон хөрөнгийг хууль ёсны болгож харагдуулахын тулд эх үүсвэрийг нь нуун далдалж, гүйлгээнд оруулах

Нэр хүндийн эрсдэл

Компанийн нэр хүнд унах, хуурамч цуу яриа олон нийтийн сүлжээгээр тархах, үүний улмаас компанийн орлого буурах, зах зээлд эзлэх байр сууриа алдах эрсдэлийг ойлгоно.

Бусад эрсдэл

Дээр дурдсан ангилалд хамаарагдахааргүй, компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд

Эрсдэлийг бүтэн дүр зургаар харж тодорхойлох, урьдчилан сэргийлэх, удирдах нь компанийн эрсдэлийн бодлогын гол зорилго юм. Тиймээс дээрх эрсдэлүүдээс гадна шинээр бий болж буй болон гэнэтийн эрсдэлүүдийг тодорхойлж, удирдах нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг.

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

Мандал даатгал нь 2022 онд байгууллагын даатгалын чиглэлээр салбартаа тэргүүлэгч гэдгээ дахин баталгаажуулж, Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн 1/3-д дангаараа даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэлээ. Тодруулбал, уул уурхай, барилга, тээвэр, худалдаа, үйлчилгээ, санхүү, үйлдвэрлэл зэрэг салбар салбарын тэргүүлэгч компаниудын хэрэгцээ шаардлагад нийцсэн хөрөнгө, хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын эрсдэлээс хамгаалах олон нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд санал болгож, түүний ард давхар даатгагдсан санхүүгийн найдвартай үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Тэр дундаа далд уурхайн нөхцөлт хамгаалалтуудыг Ллойдс-д бүртгэлтэй олон улсад А болон түүнээс дээш зэрэглэлтэй давхар даатгагчтай

хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлж харилцагч нартаа 1 сая ам доллароос эхлээд 50 сая ам доллар хүртэлх хамгаалалттай байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, бохирдлын хариуцлага, ажил олгогчийн хариуцлага зэрэг бүтээгдэхүүнийг санал болгож салбартаа анхдагч болж чадлаа.

Мөн бид байгууллагын харилцагч нартаа мэргэжлийн чанартай, найдвартай буюу санхүүгийн чадамжтай, давхар даатгагдсан үйлчилгээг хүргэж эрсдэл даах чадвартай дотоодын цорын ганц даатгагч гэдгийг баталсан Олон Улсын AM BEST агентлагаас авсан үнэлгээ болох Санхүүгийн чадавх "B", Урт хугацааны зээлжих зэрэглэл "BB+"-ийг дахин баталгаажуулав.

БИДНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАГЧ НАРТ САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Тээврийн хэрэгслийн даатгал

- Суудлын хэрэгслийн даатгал
- Хүнд даацын тээврийн хэрэгсэл
- Тусгай машин механизм

Гэнэтийн ослын даатгал

- Ажилчдын гэнэтийн осол
- Хүүхдийн гэнэтийн осол

Эрүүл мэндийн даатгал

- Дотоодын эрүүл мэнд
- Олон улсын эрүүл мэнд

Эд хөрөнгийн даатгал

- Үл хөдлөх хөрөнгө
- Бараа материал
- Тоног төхөөрөмж

Төслийн гүйцэтгэгчийн бүх эрсдэлийн даатгал

- Хөрөнгийн хохирол
- Гуравдагч этгээдийн хариуцлага

Ачааны даатгал

- Дотоод ачаа тээвэр
- Гадаад ачаа тээвэр

Хариуцлагын даатгал

- Байгууллагын ерөнхий хариуцлага
- Мэргэжлийн хариуцлага
- Ажил олгогчийн хариуцлага

Жолоочийн хариуцлагын даатгал

- Албан журмын даатгал
- Сайн дурын даатгал

Агаарын хөлгийн иж бүрэн даатгал

- Агаарын хөлгийн их бие
- Хариуцлага

ИРГЭДИЙН ДААТГАЛ

Мандал Даатгал ХК нь харилцагч иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад бүх төрлийн сувгаар хүрч, дан гагцхүү даатгалын бүтээгдэхүүн бус харилцагчдын сэтгэл ханамж, эргэх холбоог чухалчилж ажиллаж байна.

Тодруулбал, Шууд борлуулалтын баг буюу Монголын хамгийн том утсан борлуулалтын баг нь аливаа бүтээгдэхүүнийг борлуулах бус зөвлөх, чиглүүлэх, ойлгуулах зорилгыг баримтлан ажиллаж байна. Ингэснээр харилцагчдадаа даатгалын талаарх ойлгомжгүй байдлыг үгүй хийж, үр ашгийг нь хурдан хүртэхэд дэмжлэг үзүүлдэг. Бид харилцагчдад даатгалын бүтээгдэхүүнийг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн авах боломжийг олгохын зэрэгцээ цаг хугацааг хэмнэх зорилгоор даатгалын үйлчилгээг 2 минутад гүйцэтгэж байна. 2022 онд бид нийтдээ 70 гаруй мянган харилцагчдад даатгалын зөвлөгөө мэдээлэл олгож, даатгалын үйлчилгээг үзүүлээ. Мөн дижитал сувгаар дамжуулан харилцагчид өөрөө өөртөө үйлчилж, даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авч, эрсдэлийг мэргэжлийн байгууллагад шилжүүлж байгаа нь эргээд хариуцлага, хувь хүний хандлага өөрчлөгдөж байгааг илтгэж байна.

Бид Сувгийн борлуулалтын нэгж буюу арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, үүнтэй ижил үйлчилгээ үзүүлэгч финтэк апп гаргагч байгууллагуудтай хамтран даатгалын үйлчилгээг үзүүлж байна. 2022 онд бид 8 банк, 55 банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчдын эд хөрөнгө, эрүүл мэнд, ирээдүйд учирч болох гэнэтийн санхүүгийн эрсдэлээс хамтран ажиллалаа. Уг ажлын хүрээнд 10 гаруй даатгалын бүтээгдэхүүн, гэрээтэй холбоотой үйл ажиллагаа, харилцагчдад гарсан нөхөн төлбөртэй холбоотой мэдээлэл зөвлөгөөг хүссэн газраасаа авч үйлчлүүлэх нөхцөлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа жижиг дунд аж ахуйн нэгж, байгууллагуудад эрсдэлийн боловсролыг олгож, эрсдэлтэй

ажлын байр, ажил үйлчилгээний үнэлгээг Байгууллагын даатгал хариуцсан мэргэжлийн баг хамт олноороо хийлгэж, хүрч үйлчилдэг. Мөн даатгалын талаар цогц ойлголтой болгох сургалт, танилцуулга хийж, тэдэнд боловсрол олгон цаашдын ирээдүйд гарч болох эрсдэлээс хамгаалж ажилласаар ирсэн. Байгууллагууд үйл ажиллагаатайгаа холбоотойгоор хариуцлагын, эд хөрөнгийн даатгал хийхээс гадна хүндээ, ажилчдадаа чиглэсэн эрүүл мэнд, гэнэтийн осол, ажилчдын осол нөхөн олговрын даатгалыг хийлгэдэг байна. Үүний дагуу Мандал Даатгал ХК нь эрүүл мэндийн даатгалыг нөлөө бүхий олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран үйлчилж байгаа билээ. 2022 онд 700 гаруй байгууллагын 2,000 гаруй ажилчдад эрсдэлийн зөвлөгөө өгч, даатгалд хамруулан тэднийг ирээдүйд гарч болох эрсдэлээс сэргийлж, хамгаалж ажиллалаа.

Монголд эрсдэлийг удирдах боловсролын түвшин хангалтгүй байгаа нь даатгалын салбарын санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь хөгжлийг удаашруулах томоохон хүчин зүйл болж буй. Өнөөгийн нийгэмд бид маш олон эрсдэлийн дунд амьдарч байна. Орчин тойронд буй эдгээр эрсдэлүүд нь ихэвчлэн хүний хүчин зүйлсээс шалтгаалдаг ба эдгээрийг удирдаж болдог нь сайшаалтай. Гагцхүү хэн, хэрхэн, яаж гэдгийг ойлгуулах зорилгоор бид хүчээ нэгтгэн, хүсэл тэмүүлэл дүүрэн ажиллаж, улс орны эрсдэлийн түвшинг бууруулахаар сэтгэл, итгэл нэгтэй ажиллаж байна.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Манай байгууллагын үнэт зүйлсийн нэг бол бидний харилцагч. Бид харилцагчийн мэдрэмж болон үйлчилгээний чанарыг нэн тэргүүнд тавьж, салбартаа харилцагчийн үйлчилгээгээр тэргүүлэн ажиллаж байна.

Мандал даатгал нь нөхөн төлбөрийн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээг олон улсын стандартын түвшинд үзүүлдэг. Бид харилцагчийн үйлчилгээ, нөхөн төлбөрийн тусдаа хэлтэсүүдтэй, даатгалын салбартаа хамгийн том, ухаалаг дэд бүтэц, технологийн шийдлүүдийг хөгжүүлж нэвтрүүлсэн, мэргэжлийн төрөлжсөн баг бүрэлдэхүүнтэйгээр үйлчилгээ үзүүлдэг.

Omni channel - бүх сувгуудаар ижил стандартаар үйлчилгээ хүргэж байна.

Харилцагчийн үйлчилгээний 3 салбартай
Улаанбаатар, Дархан, Эрдэнэт

Харилцагчид мэдээлэл, зөвлөгөөг бүх өдрүүдэд хүргэх тусдаа call center-тэй.

Чатбот, имэйл, хэрэглэгчийн АПП, социал суваг зэрэг бүхий л боломжит сувгаар харилцагчтай харилцаж санал хүсэлтийг хүлээн авдаг.

OMNICHANNEL

Нөхөн төлбөрийн дуудлагаа 24/7 хүлээн авч, зөвлөгөө, чиглүүлэг өгөх, цахим үзлэг баримтжуулалт хийж нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэх мэргэжлийн баг ажилладаг.

Газар дээр нь үзлэг баримтжуулалт хийх өөрсдийн шуурхай менежерүүдийн багтай.

- Эрүүл мэндийн даатгалын зөвлөгөө, чиглүүлэг хүргэх тусдаа утасны шугамтай, мэргэжлийн эмч ажилладаг.
- Интермэд эмнэлэгт харилцагчийг чиглүүлж зөвлөгөө өгөх, нөхөн төлбөрийн материал хүлээн авдаг эмч ажиллаж байна.
- Эрүүл мэндийн нөхөн төлбөрийг шуурхай шийдэх 6 эмчтэй 8 ажилтны бүрэлдэхүүнтэй томоохон баг ажилладаг.

Бид харилцагчийн үйлчилгээг хялбар, шуурхай болгоход чиглэсэн олон технологийн шийдлүүд нэвтрүүлж, төслүүд хэрэгжүүлсэн.



Харилцагчид эрсдэлийн боловсрол олгох, эрсдлээс сэргийлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд платформуудыг хөгжүүлсэн.

Харилцагчийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, харилцагчийн гомдлыг стандарт хугацаанд шийдвэрлэн ажилласан.

2022 онд үйлчилгээний 8 цэг дээр үйлчилгээ авсан 59,192 харилцагчаас үнэлгээ авснаас 24,278 харилцагч эргэн хариу өгсөн, үүнээс **85 хувь болох 20,652 харилцагч САЙН үнэлгээ буюу үйлчилгээ авахад хялбар байсан үнэлгээ өгсөн.**

Мөн бид харилцагчийн үйлчилгээний стандартыг хэвшүүлэхээр тасралтгүй мониторинг хийж, сургалт, зөвлөгөөг үйлчилгээний ажилтнууддаа хүргэж ажилладаг. 2022 онд ажилтнуудын харилцагчийн үйлчилгээний стандарт 87 хувьтайгаар стандартаа барьж үйлчилгээ үзүүлсэн.

Харилцагчийн санал, хүсэлт бүр бидэнд үнэ цэнтэй.

Харилцагчийн санал гомдол, харилцагчийн дуу хоолойноос бид компанийнхаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, харилцагч төвтэй стратегийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн.

2022 онд харилцагчийн хандалт 2 хувиар өсөж 51,033 болсон байна. Үүнээс:

Лавлах төв	46,499 буюу 32% өссөн
Үйлчилгээний заал	3,795 буюу 19% өссөн

Нөхөн төлбөрийг хурдан шуурхай шийдвэрлэсэн. Үүнд:

Эрүүл мэндийн
даатгал
1 өдөрт

63%

Тээврийн хэрэгсэл албан
журмын даатгал
1 өдөрт

24%

Цахим
баримтжуулалт
1 өдөрт

52%

Харилцагчийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, харилцагчийн гомдлыг стандарт хугацаанд шийдвэрлэн ажилласан.



Лавлах төвийн цэвэр
дуудлага алдалт



Лавлах төвийн дуудлаганд
хариу өгөх хурд



Харилцагчийн лавлагааг
эхний хандалтаар
шийдвэрлэх - FCR



Харилцагчийн
үйлчилгээний стандарт



Customer effort score



Гомдол шийдвэрлэсэн
хугацаа

2022 онд үйлчилгээний 8 цэг дээр үйлчилгээ авсан 59,192 харилцагчаас үнэлгээ авснаас 24,278 харилцагч эргэн хариу өгсөн, үүнээс **85.5% хувь болох 20,652 харилцагч САЙН үнэлгээ буюу үйлчилгээ авахад хялбар байсан үнэлгээ өгсөн.**

Харилцагчийн үйлчилгээний стандартыг хэвшүүлэхээр тасралтгүй мониторинг хийж, сургалт, зөвлөгөөг үйлчилгээний ажилтнууддаа хүргэж ажилладаг. 2022 онд ажилтнуудын харилцагчийн үйлчилгээний стандарт 86 хувьтайгаар стандартаа барьж үйлчилгээ үзүүлсэн.



МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

Корпорацийн сайн засаглалын тэргүүн туршлагауудыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааг биелүүлэхэд чухал үүрэгтэй.

Компанийн засаглал нь компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм. Корпорацийн сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааны салшгүй хэсэг билээ.

Корпорацийн сайн засаглал гэдэгт:

- Системтэй шийдвэр гаргах үйл явцтай байх
- Хариуцлагын талаар ойлголт өгөх
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх
- Дотоод хяналтыг сайжруулах
- Эрсдэлийн удирдлага
- Ил тод байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа багтана.

Компанийн засаглалын тухайн хэсэгт Мандал даатгалын хувьцаа эзэмшигчдийн хурал, "Төлөөлөн удирдах зөвлөл"-ийн эрх үүрэг, хариуцлага, санхүүгийн тайлагналтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар тусгалаа.

Эрх мэдэл, хариуцлагын хуваарилалт

Компанийн хяналт болон удирдлага нь хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар), Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурал


Мандал даатгал компанийн эрх барих дээд байгууллага нь "Хувьцаа эзэмшигчдийн хурал" юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

Мандал Даатгал компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 23-ны өдөр 15:00 цагаас Шангри -Ла зочид буудал, 1-р давхрын Боллрүүм 2 хурлын танхимд хуралдсан. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар авч хэрэгжүүлсэн.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан байна. Үүнд:

1. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
5. ТУЗ-ийн хоёр ердийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж түүний оронд шинээр хоёр ердийн гишүүнийг сонгох болон
6. ТУЗ-ийн 2022 үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Компанийн засаглалын бүтэц



Төлөөлөн удирдах зөвлөл

Мандал даатгал компанийн ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ

Мандал даатгал компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь 9 гишүүнтэй байхаас 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ.

Компанийн засаглалын кодексын дагуу ТУЗ-д аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг гишүүнээр сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь компанийн үйл ажиллагаа, хөгжлийн үе шат болоод бусад нөхцөлтэй уялдсан байх

шаардлагатай.

Мандал даатгал компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхойлоход зөвлөлийн үр ашигтай байдлыг хадгалах, дээшлүүлэх явдлыг ихээхэн анхаардаг.

2022 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн зарим гишүүдийг шинэчлэн томилсон бөгөөд Мандал даатгал компанийн ТУЗ-ийн гишүүд дараах бүрэлдэхүүнтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мандал даатгал ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин удирдан чиглүүлж ажилладаг. Жилийн төлөвлөгөө, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалт, гүйцэтгэх удирдлага томилох зэрэг асуудал нь ТУЗ-өөр хянагдан, батлагддаг билээ. ТУЗ нь санхүүгийн болон стратегийн бусад зорилт, бизнесийн гол зорилтууд, эрсдэл, бизнесийн хөгжил, хөрөнгө оруулагч, гадаад харилцааны гүйцэтгэлийн тайланг тогтмол

хянах үүрэгтэй. Мөн компани нь ТУЗ-ийн гишүүдийг бүх түвшинд удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй харилцах, холбогдох бүх мэдээлэлд хандах боломжоор ханган ажиллаж байна.

ТУЗ нь 2021 онд 7 удаа ээлжит, 4 удаа ээлжит бус, нийт 11 удаа хуралдаж 16 тогтоол, шийдвэр гаргаж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ТУЗ-өөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэх асуудлуудыг хэлэлцэж баталсан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Шангри-Ла зочид буудалд амжилттай зохион байгуулсан.
- ТУЗ-өөс компанийн стратеги, бизнес төлөвлөгөөг баталсан.
- ТУЗ-өөс баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж тухай бүрт нь удирдлагын багт зөвлөмж чиглэлийг өгч ажилласан.
- Урт хугацааны буюу амьдралын даатгалын компанийн хувьцаа эзэмшигч болсон.
- Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг ТУЗ-өөс сонгодог бөгөөд Мандал Даатгал ХК-ны 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар Олон улсын Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК-ыг сонгосон.
- Мандал Даатгал ХК нь 2019, 2020, 2021 онуудад онуудад татварын дараах цэвэр ашгаасаа ногдол ашиг тараах шийдвэрийг ТУЗ-өөс гаргаж байсан бол 2022 оны 02 сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар 2021 оны татварын дараах цэвэр ашгаасаа нэгж хувьцаанд 3 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Засаглалын кодексыг хангах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэд туслах ажлын хэсгүүдийг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнаж, зөвлөмжийг хүргүүлдэг.

АУДИТ, ЭРСДЭЛИЙН ХОРОО

Мандал даатгал компанийн үйл ажиллагаа нь бүхэлдээ эрсдэлийг хэмжих, үнэлэх, удирдахтай холбоотой байдаг. Иймд ТУЗ дэргэдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, хянах үүрэгтэй “Аудит, эрсдэлийн хороо”-г ажиллуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо нь компанийн дотоод журам, тушаалын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах үүрэгтэй.

Мөн компанийн дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, дотоод хяналтын системийг хянах, ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй билээ.

Түүнчлэн компанийн нийт хүлээгдэж буй хариуцлага, түүнд харгалзах нөөцийн сан, эрсдэл даах чадварын шинжилгээтэй улирал бүр танилцаж, зохих заавар зөвлөмжийг гарган ажиллаж байна. Аудит, эрсдэлийн хороо нь 3 гишүүнтэй бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Аудит, эрсдэлийн хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Гарамдорж Гантулга даргалдаг.

Аудит эрсдэлийн хороо нь улирал бүр санхүүгийн тайланг хорооны хурал дээр авч хэлэлцсэний дараа тус санхүүгийн тайланг ТУЗ-д танилцуулдаг. Аудит эрсдэлийн хороо нь 2022 онд нийт 4 удаа хуралдаж ТУЗ-д танилцуулагдах санхүүгийн тайланг урьдчилан авч хэлэлцэж өөрсдийн дүгнэлт зөвлөмжийг ТУЗ-д өгч ажилсан байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ БОЛОН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, компанийн болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын асуудлыг зохицуулах

бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх үүрэгтэй.

Засаглалын кодексын дагуу хорооны гишүүд нь компани болон удирдлагын багаас хараат бус байхыг шаарддаг бөгөөд хорооны бүрэлдэхүүн нь энэхүү дүрэмтэй бүрэн нийцэлтэй болно. Мандал даатгалын Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороог ТУЗ-ийн гишүүн Шаравпэлжээ Гантуяа даргалдаг.

Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь 2022 онд нийт 6 удаа хуралдаж компанийн Удирдлагын багийн гүйцэтгэлийг улирал бүр хянаж, заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан байна.

Мандал даатгал ХК-ийн нэгдсэн сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны тоо

2022 оны 04 сарын 01-ны өдрийн байдлаарх Мандал даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Нэрс	Тоо ширхэг	Эзэмшил хувь
Голомт Файнэншил Групп ХХК	255,000,000	40.85%
Юу Эм Си Капитал ХХК	233,864,016	37.46%
Олон нийт	624,301,600	100.00 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ө.Ганзориг

Чэйрмен



Жэймс Двайер

ТУЗ-ийн хараат бус гишүүн



О.Ганжолоо

ТУЗ-ийн гишүүн



Л.Ганзоригт

ТУЗ-ийн гишүүн



Ш.Гантуяа

ТУЗ-ийн гишүүн



Ж.Дэлгэрсайхан

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Г.Дашдэндэв

ТУЗ-ийн гишүүн



Г.Гантулга

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Өлзийбаяр ГАНЗОРИГ

Чэйрмен

Ө.ГАНЗОРИГ НЬ САНХҮҮГИЙН САЛБАРТ ОЛОН ЖИЛ АЖИЛЛАЖ БҮЙ ТУРШЛАГАТАЙ БОЛОВСОН ХҮЧИН ЮМ. ТЭРЭЭР ЭДҮГЭЭ ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН МУЗЕЙ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, МАНДАЛ ДААТГАЛЫН ТУЗ-ИЙН ДАРГА, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЛБЫГ ТУС ТУС ХАШИЖ БАЙНА.

Ө.ГАНЗОРИГ МОНГОЛ БАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮН, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ЕРӨНХИЙ САЙДЫН ДЭРГЭДЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР ДАВХАР СОНГОГДОН АЖИЛЛАЖ ИРЖЭЭ. ТЭРЭЭР МӨН ГОЛОМТ БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, УЛААНБААТАР ХОТЫН БАНК, ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК, ТЭНГЭР ДААТГАЛ, ХАСБАНК ЗЭРЭГ БАЙГУУЛЛАГАД ХАРИУЦЛАГАТАЙ АЛБА ХАШИЖ БАЙСАН БИЛЭЭ.

Ө.ГАНЗОРИГ НЬ ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХОЛБООНЫ ДИЛЕРИЙН СЕРТИФИКАТ ЭЗЭМШДЭГ БӨГӨӨД МААСТРИХТЫН МЕНЕЖМЕНТИЙН СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗЭРЭГТЭЙ.

ШАРАВПЭЛЖЭЭ ГАНТУЯА

ТУЗ-ийн гишүүн

Хатагтай Ш.Гантуяа нь “Юу Эм Си Капитал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр өмнө нь “Монгол Ньюс” ХХК-д Маркетингийн хэлтсийн захирал, “Улаанбаатар зочид буудал” ХХК-д Маркетингийн албаны даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Ж.Дэлгэрсайхан нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн багш, дэд профессороор ажилладаг. Тэрээр 1996 оноос хойш СЭЗИС-д багшлахын сацуу, олон тооны судалгаа шинжилгээ, эрдмийн бүтээл туурвиж, Монгол Улсын санхүүгийн салбарт

үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм билээ. Ж.Дэлгэрсайхан нь Үнэт цаасны зах зээл, Хөрөнгө оруулалт, Төсөв, мөнгөний бодлогын чиглэлээр мэргэшсэн. Санхүүгийн болон бизнесийн салбар удирдах албан тушаалтнаар ажилласан ажлын туршлагатай.

Санхүүгийн Зохицуулах Хороо, МҮХАҮТ-ийн бодлогын зөвлөл, Ерөнхий сайдын дэргэдэх бодлогын зөвлөлд сонгогдон ажиллаж байв. Ж.Дэлгэрсайхан нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эдийн засгийн бакалавр, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн бакалавр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Гарамдорж ГАНТУЛГА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Г.Гантулга нь Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэл Санхүүгийн Мэргэшсэн Сургуулийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр өмнө нь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд баг, Санхүү эдийн засгийн их сургуульд Тэнхимийн эрхлэгч, багшаар ажиллаж байв.

Г.Гантулга нь Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийн Нягтлан бодогч бакалавр, Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн удирдлагын доктор зэрэгтэй.

Лувсанжамба ГАНЗОРИГТ

ТУЗ-ийн гишүүн

Л.Ганзоригт нь Монложистик Холдинг ХХК-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа. Өмнө нь Монложистик Ворлдвайд ХХК-ны Санхүү эрхэлсэн захирал мөн Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байсан.

Л.Ганзоригт нь ОХУ-ын Санкт Петербург хотын Улсын Кино Телевизийн Дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн.

Очирпүрэв ГАНЖОЛОО

ТУЗ-ийн гишүүн

Ноён О.Ганжолоо нь “Голомт Файнэншил” группийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр дэлхийн хамгийн том аудитын

компани болох Price water house Coopers-н Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан, туршлагатай мэргэжилтэн юм. Мөн “Бодь интернэшнл” ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал, Голомт банкны ТУЗ-ийн аудитын хорооны даргаар тус тус ажиллаж байв.

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийн эдийн засгийн магистр зэрэгтэй.

ЖЭЙМС БЕРНАРД Двайер

ТУЗ-ийн гишүүн

Ноён Жэймс Двайер нь Нью Йорк хотод хөрөнгө оруулалтын банкираар 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Тэрээр Shearson Loeb Rhoades болон UBS зэрэг дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкуудын M&A нэгжийг удирдан ажиллаж байжээ.

Ноён Двайер нь анх 2001 онд Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын асуудлаар Монголын Засгийн Газрыг төлөөлөх хөрөнгө оруулалтын банкираар Монголд зочилж байсан бөгөөд Хаан банкны хувьчлалд хөрөнгө оруулалтын зөвлөхөөр мөн ажилласан байна. Тэрээр 2007-2016 онд Монголын Бизнесийн Зөвлөл /BSM/-ийг үүсгэн байгуулж, захирлын албан тушаалыг хашиж байв.

Жэймс Двайер Нотр Дамын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

Гансүх ДАШДЭНДЭВ

ТУЗ-ийн гишүүн

Г.Дашдэндэв Голомт Файнэншил Групп ХХК-ны Бизнес Хөгжийн захирлаар ажилдаг. Тэр бээр, өмнө нь Голомт Банкны Уул уурхайн хэлтсийн захирлаар ажиллаж байсан туршлагатай.

Г.Дашдэндэв нь ИБУИНХУ Кардиффийн Их Сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн.

МЕНЕЖМЕНТИЙН БАГ



Ж.Батчимэг

Гүйцэтгэх захирлын орлогч



Т.Батзул

Гүйцэтгэх захирал



А.Сэлэнгэ

Давхар даатгал хариуцсан
захирал



С.Мөнгөнцэцэг

Нөхөн төлбөр, үйлчилгээ
хариуцсан захирал



Д.Жавхлан

Байгууллагын даатгал
хариуцсан захирал



Т.Дэнсмаа

Иргэдийн даатгал
хариуцсан захирал



А.Долгорсүрэн

Санхүү хариуцсан захирал



Д.Бавуугарьд

Мэдээллийн технологийн
хэлтсийн захирал



Э.Баярчимэг

Үйл ажиллагаа, хүний нөөц
хариуцсан захирал



Т.Ариунаа

Корпорэйт даатгалын
хэлтсийн захирал



Ц.Батцэнгэл

CRM, халамж үйлчилгээний
хэлтсийн захирал

Түмэннасан БАТЗУЛ

Гүйцэтгэх захирал

Т.Батзул нь Мандал даатгалын Гүйцэтгэх захирал бөгөөд Монголын банк санхүү, даатгалын салбарт 12 гаруй жил ажилласан туршлагатай, Их Британийн Уэлсийн их сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

шинээр нэвтрүүлж байсан туршлагатай. Тэрээр олон нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор хуримтлал, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаарх лекц, илтгэлүүд, мөн бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөгөө өгөх контент зэргийг тогтмол хүргэдэг.

Т.Дэнсмаа нь Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн санхүү удирдлагын бакалавр зэрэгтэй.

Жадамбасүрэн БАТЧИМЭГ

Гүйцэтгэх захирлын орлогч

Ж.Батчимэг нь дэд бүтэц, банк санхүүгийн төсөл, төслийн удирдлагын салбарт 20 орчим жил ажилласан туршлагатай бөгөөд төслийн удирдлагын зөвлөх, сургагч багш, Голомт банкны хэлтсийн захирал, Эм-Си-Эс Группт төслийн удирдлагын мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан.

Тэрээр 2021 оноос Мандал даатгалын гүйцэтгэх захирлын орлогчоор томилогдон үйл ажиллагааны нэгжүүдийг хариуцан ажиллаж байна.

Дашзэвэг ЖАВХЛАН

Байгууллагын даатгал хариуцсан захирал

Д.Жавхлан нь Мандал даатгал ХК-ийн Байгууллагын даатгал хариуцсан захирал бөгөөд одоогоор тус компанийн Корпорейт харилцагчийн даатгалын борлуулалт, CRM, нөхөн төлбөр, халамж, үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт байгууллагын даатгалын чиглэлээр 8 дахь жилдээ ажиллаж байна.

Д.Жавхлан нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй.

Адъяажав Долгорсүрэн

Санхүү хариуцсан захирал

А.Долгорсүрэн нь Мандал Даатгал ХК-ийн Санхүү хариуцсан захирал бөгөөд даатгалын салбарт гурав дахь жилдээ ажилласан туршлагатай, Лондонгийн Санхүү Бизнесийн Сургуулийн санхүүгийн магистр зэрэгтэй ба Олон улсын итгэлжлэгдсэн санхүүгийн шинжээчийн 2 түвшинг 2019 онд давсан.

Аварзэд Сэлэнгэ

Давхар даатгал хариуцсан захирал

А.Сэлэнгэ нь Мандал Санхүүгийн Нэгдэл (Мандал Даатгал ХК)-ийн Давхар даатгал хариуцсан захирал бөгөөд даатгалын салбарт давхар даатгалын чиглэлээр 5 жил ажилласан туршлагатай, Их Британийн Тусгай Эрхт Даатгалын Институт CII-ийн Давхар Даатгалын Диплом (Diploma CII)-ын зэрэгтэй.

Тогтох ДЭНСМАА

Иргэдийн даатгал хариуцсан захирал

Т.Дэнсмаа нь Мандал даатгалын Иргэдийн даатгал хариуцсан захирал бөгөөд өмнө нь Голомт банкны бизнес хөгжлийн хэлтсийн захирал, ХасБанкны хэлтсийн захирал, ахлах менежерээр ажиллаж байсан. Корпорейт байгууллагын бизнес хөгжүүлэлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт чиглэлд ажиллаж олон бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд

Тэрбээр Америкийн Нэгдсэн Улсын, Калифорни Мужид байрлах Голдэн Гэйт Их Сургуулийн Санхүүгийн Шинжлэх Ухааны Шинжлэх Ухааны Магистр зэрэгтэй.

Сэлэнгэ МӨНГӨНЦЭЦЭГ

Нөхөн төлбөр, үйлчилгээ хариуцсан захирал

С.Мөнгөнцэцэг нь Мандал даатгалын Нөхөн төлбөр, Үйлчилгээ хариуцсан захирал. Тэрээр үүрэн холбоо, банк санхүүгийн салбарын томоохон компаниуд болох Мобиком корпорац, ХААН банк болон Голомт банкинд сүүлийн 10 гаруй жил бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалт, үйлчилгээний бодлого, чанарын хяналт, үйл ажиллагааны сайжруулалт, сургалт хөгжлийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Түүнчлэн Бизнесийн зөвлөх үйлчилгээний компанид Харилцагчийн үйлчилгээний сургалт, судалгааны чиглэлийг хариуцан ажиллаж, томоохон төслүүд хэрэгжүүлсэн.

С.Мөнгөнцэцэг нь Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Мэдээллийн системийн менежмент болон Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүү менежментийн бакалавр зэрэгтэй.

Цэрэндорж БАТЦЭНГЭЛ

CRM, Халамж үйлчилгээний хэлтсийн захирал

Ц.Батцэнгэл нь Мандал даатгалын CRM, Халамж үйлчилгээний хэлтсийн захирал бөгөөд компанийн CRM систем, халамжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр банкинд 9 жил, хөрөнгө оруулалт, даатгалын чиглэлээр 3 жилийн туршлагатай. Хасбанк, Голомт банкны бүс хариуцсан менежерээр ажиллаж гүйцэтгэлийн үнэлгээ, дата анализ, систем хөгжүүлэлт чиглэлээр ажиллаж байсан.

Ц.Батцэнгэл нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй.

Түвшинжаргал АРИУНАА

Корпорейт даатгалын хэлтсийн захирал

Т.Ариунаа нь Мандал даатгалын Корпорейт даатгалын хэлтсийн захирал бөгөөд компанийн корпорейт даатгалын борлуулалтын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь МИГ даатгал ХХК-ийн Эрх зүй, Нөхөн төлбөрийн газрын захирлаар ажиллаж байсан бөгөөд даатгалын салбарт Нөхөн төлбөр, Хууль, эрх зүйн чиглэлээр 10 жил ажилласан туршлагатай.

Т.Ариунаа нь Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Эрх зүйн бакалавр зэрэгтэй.

Дорж БАВУУГАРЬД

Мэдээллийн технологийн хэлтсийн захирал

Д.Бавуугарьд нь Мандал даатгалын Мэдээллийн технологийн хэлтсийн захирлаар ажилладаг. Тэрээр Хадгаламжийн банк, Монгол шуудан банк, Төрийн банк, Улаанбаатар хотын банканд мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж байсан бөгөөд банк санхүүгийн салбарт 20 жил ажилласан туршлагатай.

Д.Бавуугарьд нь Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн физик электроникийн бакалавр зэрэгтэй.

Энхтайван БАЯРЧИМЭГ

Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн захирал

Э.Баярчимэг нь Мандал даатгалын Захиргаа, Хүний нөөцийн хэлтсийн захирлаар ажилладаг ба компанийн хүний нөөц, сургалт хөгжлийн бодлого, үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр Ньютел, Скайтел компаниудад Захиргааны хэлтсийн менежерээр ажиллаж байсан, хүний нөөцийн чиглэлээр 7 жил, банк санхүүгийн байгууллагад 5 жил ажилласан туршлагатай.

Э.Баярчимэг нь Улаанбаатарын их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Accountants &
business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюдинг, #602 тоот,
Жамьян гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979

Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref: 01/MD/23/08152022/BP

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК -ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид “МАНДАЛ ДААТГАЛ” ХК (цаашид “Компани” гэх) –ийн 2022 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхиуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцоолууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА
Гүйцэтгэх захирал



ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2023 оны 02 дугаар сарын 15

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Даатгалын хураамжийн нийт орлого	5	35,614,683	69,687,367
Даатгалын хураамжийн буцаалт	5	(1,217,596)	(1,909,141)
Давхар даатгалын хураамжийн зардал	5	(15,730,123)	(45,816,256)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		18,666,963	21,961,968
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	5	(3,573,794)	(11,779,019)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	5	3,221,319	10,428,336
Орлогод тооцсон хураамж		19,019,437	20,611,285
Нийт нөхөн төлбөрийн зардал	6	8,150,304	11,062,366
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	6	1,132,089	1,260,840
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	6	161,533	127,587
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		6,856,681	9,673,938
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	6	302,849	(961,833)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	6	457,609	30,696
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	6	318,044	514,546
Зардалд тооцсон нөхөн төлбөр		7,935,184	9,257,348
Даатгалын гэрээний зардал	7	(1,858,376)	(2,564,169)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	8	207,257	451,173
Хөрөнгө оруулалтын орлого ба олз	9	5,009,599	4,884,880
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		14,442,732	14,125,821
Эрхийн шимтгэлийн орлого	10	10,390	8,762
Бусад орлого	11	97,129	48,793

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(7,269,853)	(8,729,319)
Борлуулалт, маркетингийн зардал	12	(937,146)	(892,135)
Санхүүгийн зардал	13	(100,294)	(51,449)
Бусад зардал	14	(40,094)	(40,094)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15	80,099	9,651
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	16	18,839	60,866
Бусад ашиг (алдагдал)		(8,140,931)	(9,647,134)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		6,301,802	4,478,686
Орлогын татварын зардал	17	693,811	394,280
Татварын дараах ашиг (алдагдал)		5,607,991	4,084,406
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг			
Тайлант үеийн цэвэр ашиг		5,607,991	4,084,406
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		1,334,440	318,137
Орлогын нийт дүн		6,942,431	4,402,544

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө			
Бэлэн мөнгө	2	3,867	347,427,629
Харилцахад байгаа мөнгө	2	3,683,532	690,237
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн		3,687,400	1,037,665
Даатгалын авлага			
Даатгалын хураамжийн авлага	3	6,830,235	8,436,032
Буруутай этгээдээс авах авлага	3	146,689	104,498
Давхар даатгалаас авах авлага	3	529,155	18,733
Даатгалын авлагын дүн		7,506,079	8,559,264
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бусад авлага	4	41,692	82,680
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн		41,692	82,680
Бусад санхүүгийн бус хөрөнгийн			
НДШ авлага, бусад татварын авлага	5	396	27,642
Хойшлогдсон татварын хөрөнгө	5	-	79,749
Бараа материал	7	142,781	204,497
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6	746,569	1,190,139
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн		889,747	1,502,028
Хөрөнгө оруулалт			
Хадгаламж, хадгаламжийн сертификат	8	8,672,140	4,507,472
Үнэт цаас	9	25,918,076	34,366,134
Хөрөнгө оруулалтын дүн		34,590,216	38,873,607
Даатгалын хөрөнгө			
Хойшлогдсон давхар даатгалын хураамж	11	9,043,414	19,471,750
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг	11	310,254	279,558
Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	11	996,001	1,473,530
Даатгалын хөрөнгийн дүн		10,349,669	21,224,839
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	12	1,300,408	2,111,575
Биет бус хөрөнгө /Цэвэр/	13	261,972	164,173
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20	58,627,188	73,555,835

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч			
Өр төлбөр			
Даатгалын өглөг			
Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	14	132,929	247,949
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	14	212,901	309,515
Давхар даатгагчид өгөх өглөг	14	3,747,174	5,767,389
Даатгалын өглөгийн дүн		4,093,005	6,324,854
Бусад санхүүгийн өр төлбөр			
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	15	193,672	235,354
Ногдол ашгийн өглөг	16	19,073	19,073
Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн		212,745	254,428
Бусад санхүүгийн бус өр төлбөр			
Цалингийн өглөг	18	169,500	1,440
НДШ-ийн өглөг	18	1,359	249
ААНОАТатварын өглөг	17	130,670	453,435
ХХОАТатварын өглөг	17	96,046	160,311
Урьдчилж орсон орлого	18	773,307	756,530
Бусад санхүүгийн бус өр төлбөр	18	552,520	331,807
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн		1,723,404	1,703,775
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	18	17,797,291	29,576,311
Нөхөн төлбөрийн нөөц сан			
Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	20	2,062,732	1,883,811
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	20	2,370,017	1,587,105
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	20	1,353,611	1,868,158
Тусгай нөөц сан	20	1,256,290	1,256,290
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн		7,042,650	6,595,364
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		30,869,097	44,454,733
Эздийн өмч			
Эзэмшигчдийн өмч	24	6,243,016	6,243,016
Нэмж төлөгдсөн капитал	26	4,441,895	4,441,895
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25	1,187,291	318,137
Хуримтлагдсан ашиг, алдагдал	27	15,885,887	18,098,052
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		27,758,090	29,101,101
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		58,627,188	73,555,835

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн нийт орлого	28	35,614,682	69,687,367
Даатгалын хураамжийн буцаалт	28	(1,217,596)	(1,909,141)
Давхар даатгалын хураамжийн зардал	28	(15,730,123)	(45,816,257)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		18,666,963	21,961,969
Орлогот тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	28	(3,573,794)	11,779,020
Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	28	3,221,319	10,428,336
Орлогот тооцсон хураамж		19,019,437	20,611,285
Нийт нөхөн төлбөрийн зардал	28	8,150,304	11,062,367
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	28	1,132,089	1,260,840
Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр	28	161,533	127,588
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		6,856,681	9,673,938
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт	28	302,849	(961,833)
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	28	457,609	30,696
Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт	28	318,044	514,547
Зардалд тооцсон нөхөн төлбөр		7,935,184	9,257,348

мянган төгрөг	Тодруулга	2021	2022
Даатгалын гэрээний зардал	29	(1,858,376)	(2,564,169)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	30	207,257	451,173
Хөрөнгө оруулалтын орлого	31	5,009,599	4,884,881
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		14,442,732	14,125,821
Эрхийн шимтгэлийн орлого	31	10,389	8,763
Бусад орлого	32	97,129	48,794
Ерөнхий ба удирдлагын зардал	35	(7,269,853)	(8,729,320)
Борлуулалт, маркетингийн зардал	36	(937,145)	(892,135)
Санхүүгийн зардал	38	(100,294)	(51,449)
Бусад зардал	39	(40,094)	(102,305)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	33	80,099	9,652
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	34	18,839	60,867
Бусад ашиг (алдагдал)		(8,140,931)	(9,647,134)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		6,301,802	4,478,687
Орлогын татварын зардал	40	693,811	394,280
Татварын дараах ашиг (алдагдал)		5,607,991	4,084,407
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		5,607,991	4,084,407
Дахин үнэлгээний нэмэгдэл	25	1,334,440	318,137
Орлогын нийт дүн		6,942,431	4,402,544

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

мянган төгрөг	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	Нийт
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,243,016	4,441,896	(147,149)	12,116,428	22,654,191
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	34,374	34,374
Залруулсан үлдэгдэл	6,243,016	4,441,896	(147,149)	12,150,801	22,688,564
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,607,991	5,607,991
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,334,439,928	-	1,334,440
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,872,905)	(1,872,905)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,243,016	4,441,896	1,187,291	15,885,887	27,758,090
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,872,241)	(1,872,241)
Залруулсан үлдэгдэл	6,243,016	4,441,895	1,187,291	15,885,887	25,885,848
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	4,084,406	4,084,406
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(869,154)	-	(869,154)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,243,016	4,441,895	318,137	18,098,052	29,101,101

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

мянган төгрөг	2020	2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	34,958,698	63,961,782
Даатгалын хураамжийн орлого	32,595,228	62,466,706
Давхар даатгалын нөхөн төлбөр	616,820	190,324
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	18,295
Бусад мөнгөн орлого	1,746,650	1,286,457
Мөнгөн зарлагын дүн (-)	32,236,559	64,169,236
Ажиллагчдад төлсөн	3,434,664	4,100,642
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	885,080	1,203,155
Бараа материал худалдан авахад төлсөн	346,474	62,801
Ашиглалтын зардалд төлсөн	92,355	670,955
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	13,495,174	40,904,802
Нөхөн төлбөрт төлсөн	8,170,210	10,501,968
Үүнээс: Сайн дурын даатгалын	7,248,407	8,598,694
Албан журмын даатгалын	921,803	1,903,274
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	347,229	332,930
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	903,026	1,532,648
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	-	2,794
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	76,551	49,680
Татварын байгууллагад төлсөн	1,384,056	602,099
Даатгалын төлбөрт төлсөн	2,932	13,605
Бусад мөнгөн зарлага	3,098,807	4,191,156
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,722,139	(207,455)

мянган төгрөг	2020	2021
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	69,901,733	30,755,230
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	247,600
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	65,696,054	27,347,989
Хүлээн авсан хүүний орлого	4,105,490	3,046,952
Хүлээн авсан ногдол ашиг	100,189	112,688
Мөнгөн зарлагын дүн (-)	69,266,452	31,503,975
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	398,413	1,100,004
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	110,783	22,440
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	68,757,257	30,381,532
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	635,281	(748,745)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	(52)	-
Валютын ханшийн зөрүү	(52)	-
Мөнгөн зарлагын дүн (-)	1,900,301	1,693,535
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	203,974	-
Төлсөн ногдол ашиг	1,696,327	1,693,535
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,900,354)	(1,693,535)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,457,066	(2,649,735)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,230,334	3,687,400
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,687,400	1,037,665

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Компанийн талаарх ерөнхий мэдээлэл

“Мандал Даатгал” ХК нь 2011 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Монгол улсад үүсгэн байгуулагдаж Санхүүгийн Зохицуулах Хорооноос ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан.

2018 оны 9 дүгээр сарын 25 -ны өдрийн байдлаар “Мандал Даатгал” ХК нь нийт 624,301,600 ширхэг энгийн хувьцааг эргэлтэнд гаргасан нь бүрэн эргэлтэнд байна. 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Хувьцаат компани болсон.

Одоогоор компанийн эргэлтэнд байгаа нийт энгийн хувьцааны эзэмшил дараах байдалтай байна. Үүнд:

- Голомт Файнэншл Групп ХХК - 40.85%
- Юу Эм Си Капитал ХХК - 37.48%
- Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК - 7.27%
- Бусад – 14.4%

“Мандал Даатгал” ХК нь 2020 онд Олон улсын үнэлгээний “AM Best” агентлагаас санхүүгийн чадавхи болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ авсан анхны Монгол компани болсон ба 2021 онд “AM Best” агентлагаар үнэлгээгээ дахин баталгаажуулж, ерөнхий санхүүгийн чадавхи нь “В”, урт хугацааны зээлжих зэрэглэл “BB+” гэж тус тус үнэлэгдсэн бөгөөд цаашдын төлөв нь “Тогтвортой” хэмээн үнэлэгджээ.

“Мандал Даатгал” ХК нь 2022 оны байдлаар ердийн даатгалын 15 хэлбэрээр бүтээгдэхүүн гарган, даатгалын үйл ажиллагаагаа эрхэлж, Өмнөговь, Дархан-Уул болон Орхон аймгуудад салбар төлөөлөгчийн газартайгаар ажиллаж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Нийцтэй байдлын мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”) –д нийцүүлэн 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Сангийн сайдын 132 дугаар тушаалаар батлагдсан “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн маягт, тодруулга, аргачлалын дагуу бэлтгэсэн байна.

Хэмжилтийн суурь

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Тасралтгүй үйл ажиллагаа

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой тодорхойгүй байдал байхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцоололоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварын дарааллаар толилуулсан.

Зөвхөн хуулиар эрх олгосон тохиолдолд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрч Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулснаас бусад тохиолдолд орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнаж болохгүй.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кассад байгаа бэлэн мөнгө, банканд байршуулсан бэлэн мөнгөнөөс (3 сар хүртэлх сарын хугацаатай хадгаламж) бүрдэнэ. Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар сайтай хөрөнгө болно.

Даатгалын авлага

Даатгалын гэрээ гэдэг нь даатгагч байгууллага даатгуулагч талын томоохон

эрсдэлийг хүлээн авч хэрэв даатгуулагчид сөрөг нөлөө бүхий ирээдүйн тодорхойгүй үйл явдал/ даатгалын тохиолдол/ үүсвэл нөхөн төлбөр олгох гэрээг хэлнэ.

Даатгалын гэрээ нь санхүүгийн хэрэглүүрийн болон үйлчилгээний гэрээний шинж чанарыг нэгтгэсэн байдаг. Түүнээс гадна олонхи даатгалын гэрээнүүд урт хугацааны төрөл бүрийн гэрээнээс олох мөнгөн орлогыг агуулсан байдаг.

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх эрхтэй дүн байна. Үүнд: даатгалын хураамжийн авлага, буруутай этгээдээс авах авлага, давхар даатгагчаас авах авлага орно.

Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар баталсан Даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн зааврын 3.2 Даатгалын авлага хэсэгт “Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно” гэж заасны дагуу авлагын шууд аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл авлага төлөгдөх найдваргүй гэдэг нь тогтоогдсон үед авлагыг данснаас хасдаг.

Даатгалын хөрөнгө

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) болон Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр хүлээн зөвшөөрдөг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг юм.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог.

Даатгалын орлогын шимтгэлийн

хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

Бараа материал

Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдон гарсан бусад зардал орно. Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана.

Цэвэр боломжит үнийг тооцоход бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасаж тооцно.

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг уг жил гүйлгээ гарсан өдрийн ханшид үндэслэн Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж нэгэн зэрэг бүртгэдэг.

Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст хаалтын ханшийг үндэслэн хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр илэрхийлэгдсэн, анх гадаад валютаар гарсан мөнгөн бус зүйлсийг түүнийг олж бэлтгэх үеийн түүхэн ханшийг

ашиглан хөрвүүлж бүртгэдэг.

1 (нэг) ам долларын төгрөгтэй харьцах албан ханш:

2021 оны 12 дугаар сарын 31	2,848.80
2022 оны 12 дугаар сарын 31	3,444.60

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Үндсэн хөрөнгийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй цэвэр үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэ(үлдэгдэл өртөг)-тэй харьцуулж тодорхойлдог ба олз, гарзыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Машин тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглагдах хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдүүлж, элэгдлийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

• Барилга	25 жил
• Машин тоног төхөөрөмж	10 жил
• Тээврийн хэрэгсэл	10 жил
• Тавилга, эд хогшил	10 жил
• Компьютер түүний дагалдах хэрэгсэл	2 жил
• Бусад үндсэн хөрөнгө	10 жил

Түрээсэлсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгөөр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа нөхцөлд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Тухайн тохиолдолд хэлцлийн шинж байдлыг үнэлсний үр дүнд хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийг хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Компанийн түрээсэлж буй хөрөнгийн ангилал

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлэх нөхцөлтэй бол санхүүгийн түрээсээр,
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээсээр ангилна.

Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээсэлсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээсэлсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжих эсэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

Үйл ажиллагааны түрээс

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгө ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүдийг түрээсийн хугацааны тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр орлого зардлаар тайлагнадаг.

Даатгалын ба бусад өглөг

Даатгалын ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараах үед хорогдуулсан өртгөөр

илэрхийлнэ. Даатгалын өглөгт даатгалын үйл ажиллагаатай холбоотой өглөгүүд хамаарна. Үүнд: даатгалын хураамжийн буцаалтын өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөг, давхар даатгагчид өгөх өглөг хамаарна.

Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Даатгалын нөөц сан

Нөөц сангуудыг даатгалын төрөл тус бүрээр байгуулна. Үүнд: Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС).

ОТХН-д даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсэг ордог.

УБМХНС-г тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдолд нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардлагатай дүнгээр хэмждэг.

УБХНС-г тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сангаар хэмждэг.

МБТХНС-г даатгалын тохиолдолд болсон тухай даатгагч мэдэгдсэн боловч төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр тодорхойлдог.

Даатгалын нөөц сангийн тооцоолол

Компанийн актуарч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу даатгалын хураамжийн нөөц болон даатгалын нэхэмжлэлийн нөөц сангуудыг тооцоолдог.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг (ОТНХ) даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд "хувь тэнцүүлсэн арга"-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлогддог. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг (УБМХНС) даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистик тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд (МБТХНС) тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, и-мэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг (УБХНС) даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

Аудитын явцад нөөц сангийн тооцооллыг хөндлөнгийн шинжээч-актуарч давтан тооцоолж, шалгасан.

Санхүүгийн хэрэглүүр

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө ажил гүйлгээ

хийсэн өдөр хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэх ба тухайн бодит үнэ цэнэ эсвэл хүлээн авсан Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хэмжихдээ гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ. Компанийн санхүүгийн хөрөнгөд зээл ба авлага орно.

(ii) Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүр бус санхүүгийн хөрөнгө юм.

Анх хүлээн зөвшөөрсний дараа санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ:

- Хорогдуулсан өртгөөр
- Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр үнээр
- Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тус тус хэмжинэ.

Хэмжилтийн сонголт нь санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар, гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанараас хамаарна.

Санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн байгаа үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Компанийн санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө дараа үед хорогдуулсан өртгөөр, бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор ("БҮЦӨБДО"), бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлаар ("БҮЦӨАА") илэрхийлэгдэх гэж ангилна.

Анхлан хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн ангилал нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар ба Компанийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараас хамаарна.

Компани нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэггүй борлуулалтын авлагаас

бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх хөрөнгөөс бусад хөрөнгийн бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр эсвэл БҮЦӨБДО-р ангилахын тулд гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт болон үлдэгдэл төлбөрт ногдох хүүгийн төлөлтөөс бүрдсэн байх шаардлагатай. Энэ үнэлгээ нь "зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр" ("ЗҮХТ") шалгуур гэж нэрлэгддэг ба хэрэглүүр тус бүрд хийгдэнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн загвар нь мөнгөн урсгалыг бий болгохын тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдахыг тодорхойлох учиртай. Бизнесийн загвар нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах, санхүүгийн хөрөнгийг борлуулж ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх, эсвэл хоёуланг нь хэрэгжүүлэх замаар мөнгөн урсгал үүсэх эсэхийг тодорхойлно. Хөрөнгийн зах зээл дээр зохицуулалт, дүрэм журмаар тогтоосон хугацаанд (хэвийн нөхцөлтэй арилжаа) санхүүгийн хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг худалдан авалт буюу борлуулалтыг борлуулалтын өдөр хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын өдөр нь тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл худалдах үүрэг авсан өдрийг илэрхийлнэ. Бизнесийн загварын үнэлгээ Компани нь бизнесийнхээ загварыг тодорхойлохдоо өөрийн бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдаж буйг хамгийн зөв илэрхийлж чадах загварыг сонгох шаардлагатай.

Компанийн бизнесийн загварыг хэрэглүүр тус бүрээр нь биш багцын түвшинд үнэлэх бөгөөд дараах ажиглагдах хүчин зүйлсэд суурилдаг

- Бизнесийн загвар ба тухайн бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх ба байгууллагын тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд тайлагнах
- Бизнесийн загварын ба тухайн бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлүүд болон тухайн эрсдэлийг удирдан зохицуулах
- Бизнесийн удирдлагын албан тушаалтнуудад олгосон олговор

(жишээлбэл, олговор нь удирдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнэд эсвэл гэрээний мөнгөн гүйлгээ цуглуулсан хувь хэмжээнд суурилсан эсэх)

- Үнэлгээний чухал асуудлуудад борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ, цаг хугацаа нь мөн орно

Бизнесийн загварын үнэлгээ нь "хамгийн муу хувилбар" буюу "стресс хувилбар"-ыг үл харгалзан боломжит хувилбарууд дээр үндэслэнэ. Хэрвээ анхлан хүлээн зөвшөөрөлтийн дараа мөнгөн гүйлгээ нь Компанийн анхны хүлээлтээс ялгаатай бол Компани нь тухайн бизнесийн загварт үлдсэн санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөхгүй бөгөөд ирээдүйд шинээр үүсэх эсвэл худалдан авах санхүүгийн хөрөнгийг үнэлэхэд тухайн мэдээллийг ашиглана.

"Зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр" ("ЗҮХТ") шалгуур

Санхүүгийн хөрөнгийн ангиллын үйл явцын дараагийн шат нь Компани нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоохын тулд санхүүгийн гэрээний нөхцөлийг үнэлэхэд суурилна.

Энэхүү шалгуурын хувьд "үндсэн төлбөр"-ийг санхүүгийн хөрөнгийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ гэж тодорхойлдог бөгөөд санхүүгийн хөрөнгийн хугацааны туршид өөрчлөгдөж болно. (жишээлбэл, үндсэн төлбөрийн эргэн төлөлт, урамшуулал/хөнгөлөлтийн хорогдол байгаа тохиолдолд).

Зээлийн хэлцлийн хүүгийн түвшний хамгийн чухал элемент нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг болон зээлийн эрсдэлийг тооцоход оршдог. "Зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр" үнэлгээг хийх нь ихээхэн үнэлэмж шаарддаг бөгөөд хүү тооцох хугацаа зэрэг холбогдох хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

Нөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний заалт эсвэл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн гүйлгээний тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээгээрх мөнгөн гүйлгээнд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд хөрөнгийг БҮЦӨАА-р бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилах шаардлагатай.

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр

Энэ ангилал нь Компанийн хувьд хамгийн ач холбогдолтой ангилал юм. Компани нь санхүүгийн хөрөнгийг дараах хоёр нөхцөл зэрэг хангагдсан үед хорогдуулсан өртгөөр илэрхийлэхээр ангилна:

- Бизнесийн загварын зорилго: гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулан авах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшиж байгаа; ба
- Гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар: тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн үндсэн төлбөр ба үүнд үндэслэн тооцоолсон хүүгийн төлбөр төлөгдөнө.

Санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ нягтлан бодох бүртгэлийн хэлбэрээс мөн чанарыг илүүд үзэх зарчмыг баримтална.

Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийг дараах үеүдэд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр үнэлж хэмжих бөгөөд хөрөнгийн үнэ цэний бууралтыг тооцох шаардлагатай.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх, өөрчлөх эсвэл хөрөнгө нь үнэ цэний бууралтад орох үед үүсэх олз ба гарзыг ашиг, алдагдалд

хүлээн зөвшөөрнө.

Компанийн хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх хөрөнгө нь худалдан авсан зээлийн багцын авлага ба зээлийн авлага данснаас бүрддэг.

Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор (БҮЦӨБДО) бүртгэгдэх өрийн хэрэглүүр

Компани нь санхүүгийн хөрөнгийг дараах хоёр нөхцөл зэрэг хангагдсан үед БҮЦӨБДО-р бүртгэгдэх өрийн хэрэглүүрээр ангилна:

- Бизнесийн загварын зорилго: гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах мөн санхүүгийн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж байгаа; ба
- Гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар: тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн үндсэн төлбөр ба үүнд үндэслэн тооцоолсон хүүгийн төлбөр төлөгдөнө.

БҮЦӨБДО-р бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн

хувьд хүүгийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүний олз ба гарз, үнэ цэний бууралтын алдагдал ба буцаалтын орлогыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч, хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгөтэй адил тооцдог.

Бодит үнэ цэнийг дахин хэмжих үед дансны үнэд орсон бусад өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хуримтлуулан хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэний олз эсвэл гарзыг ашиг, алдагдалд шилжүүлнэ.

Компани нь 2022 оны 12 сарын 31-ны байдлаар БҮЦӨБДО өрийн хэрэглүүр байхгүй байна.

БҮЦӨБДО-р бүртгэгдэх өмчийн хэрэглүүр

Компани нь өөрийн өмчийн хөрөнгө оруулалтыг анхлан хүлээн зөвшөөрөхөд НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулгад заасан өөрийн өмчийн тодорхойлолтод нийцэх хөрөнгө оруулалтыг арилжаалах зорилгоор эзэмшээгүй тохиолдолд БҮЦӨБДО-р бүртгэгдэх өмчийн хэрэглүүрээр хүлээн зөвшөөрөх сонголтыг эргэлт буцалтгүйгээр хийж болно. Энэ сонголтыг хөрөнгө оруулалт тус бүрд хийх боломжтой юм.

БҮЦӨБДО-р бүртгэгдэх өмчийн хэрэглүүрийн үнэ цэний бууралт тооцож, сан байгуулах шаардлагагүй.

Бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (БҮЦӨАА) бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

БҮЦӨАА-р бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө ангилалд арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө, анхлан хүлээн зөвшөөрөх үед БҮЦӨАА-р бүртгэгдэх хөрөнгөөр ангилахаар сонгосон хөрөнгө болон зайлшгүй бодит үнэ цэнээр хэмжигдэх хөрөнгө орно.

Ойрын хугацаанд эргүүлэн худалдах зорилгоор худалдан авсан санхүүгийн хөрөнгүүдийг худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө гэж ангилна.

Үр нөлөөтэй хэйджингийн хэрэглүүр гэж тусгайлан нэрлээгүй л бол үүсмэл хэрэглүүрийг (агуулагдаж байсан үндсэн гэрээнээс нь салгасан үүсмэл хэрэглүүр орно) мөн худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө гэж ангилна.

Бизнесийн загвараас үл хамааран зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр нөхцөлийг хангаагүй мөнгөн гүйлгээтэй санхүүгийн хөрөнгийг БҮЦӨАА-р бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилдаг.

Дээр дурдсан хорогдуулсан өртгөөр мөн БҮЦӨБДО-р бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн шалгуурыг үл харгалзан өрийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрөхөд тухайн хөрөнгийг БҮЦӨАА-р бүртгэх хөрөнгөөр хэмжих нь нягтлан бодох бүртгэлийн үл нийцлийг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр багасгахаар байвал, тухайн ангилалд оруулж болно.

БҮЦӨАА-р бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь бүртгэж, бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан;
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн; мөн:
- Компани хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн;
- Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн

хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-ын загварын дагуу, аж ахуйн нэгжүүд хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт ажиглагдсан үед зээлийн үнэ цэний нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдлыг (“Нийт хугацаанд зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал” буюу “ЗҮЦНХХА”) -г хүлээн зөвшөөрнө. Тус өсөлт нь ажиглагдаагүй хөрөнгөд зээлийн үнэ цэний 12 сарын хугацаанд хүлээгдэж буй алдагдлыг (“ЗҮЦ12сХА”) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ЗҮЦ12сХА нь тайлангийн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хэрэгжих болзошгүй санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйжих үйл явдлын үр дүнд үүссэн хүлээгдэж буй алдагдлыг илэрхийлж буй ЗҮЦНХХА -ын хэсэг юм.

Санхүүгийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхийг тус санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацааны туршид зээлийн чанаргүйжих эрсдэл нь хэрхэн өөрчлөгдөхийг харгалзан үзэж шийдвэрлэнэ. Үүнийг үндэслэн санхүүгийн хөрөнгийг Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3 зэрэгт бүлэглэсэн болно:

Шатлал 1: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхөд үнэ цэний бууралтыг ЗҮЦ12сХА-д суурилан тооцно. Шатлал 1-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 2-оос шилжин орж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.

Шатлал 2: Санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт ажиглагдсан хөрөнгөд тухайн хөрөнгийн үнэ цэний бууралтыг ЗҮЦНХХА-д суурилан тооцно. Шатлал 2-т мөн зээлийн эрсдэл нь сайжирч, Шатлал 3-аас

шилжиж орж ирсэн санхүүгийн хөрөнгө багтана.

Шатлал 3: Санхүүгийн хөрөнгө нь чанаргүй төлөвт орсон бөгөөд үнэ цэний бууралтыг ЗҮЦНХХА-д суурилан тооцно.

Үнэ цэний бууралтын алдагдал болон буцаалтыг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийн залруулгаар олз болон гарзаас тусад нь бүртгэж тодруулна.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрүүд буюу зээл, зээлээр авсан эх үүсвэр, өглөг, хэйджийн хэрэглүүрээр ашиглах үүсмэл хэрэглүүр зэргийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн өр төлбөрөөр бүртгэнэ.

Бүх санхүүгийн өр төлбөр буюу зээл, зээлээр авсан эх үүсвэр, өглөг зэргийг тэдгээртэй хамааралтай ажил гүйлгээний зардлуудыг оруулан анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.

Зээл ба зээлээр авсан эх үүсвэр

Компанийн зээл болон зээлээр авсан эх үүсвэрүүд нь ихэвчлэн баталгаажсан боңд болон бусад өр төлбөрүүдээс бүрдэж байна.

Анхлан хүлээн зөвшөөрсний дараа хүүтэй зээл болон зээлээр авсан эх үүсвэрийг үр ашигт хүүгийн түвшин (ҮАХТ)-ий аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ.

Өр төлбөрийг данснаас хасах болон ҮАХТ-ий хорогдуулалтын үе шатнаас үүссэн олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Хорогдуулсан өртгийг худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал болон ҮАХТ-ий нэг хэсэг болох шимтгэлийн зардал зэргийг авч үзсэний үндсэн дээр тооцоолно. ҮАХТ-ий хорогдуулалтын зардал нь ашиг, алдагдлын тайлангийн "хүүгийн зардал"-д багтсан болно. Энэхүү ангилал нь ерөнхийдөө хүүтэй зээл болон зээлээр авсан эх үүсвэрүүдэд хамаатай.

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан

эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд зохих журмын дагуу хөрөнгө борлуулснаас орж ирэх эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийн бодит үнэ байна.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээнд үндэслэн хийдэг. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн давуу зах зээлд

Үндсэн зах зээл болон хамгийн давуу зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээл байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадах эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгөх нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай орцууд хангалттай үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн

багаар ашиглана.

